

Шүд хорхойтвол тунгалгийн булчирхай өвчилнө

Тунгалгийн булчирхай цочиж, үрэвсэхэд гэхайн хавдартай эндүүрэх нь бий. >4

Мартагдсан алаг даахай

Одоогоор Монголд алаг даагыг судалсан хүн байхгүй. >7

Сонголтгүй сонголт

Төсөв санхүүгийн дэг журам тогтох нь орж ирэх мөнгөн дүнгээс илүү чухал. >11



■ Кимийн үхэл ба Умард Солонгосын худалдаа
■ Европын холбоо "Торгоны зам"-ыг таашаахгүй бололтой

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.02.22, ЛХАГВА ~ №037 (583)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

УИХ-ын ээлжит бус чуулганыг ирэх сарын 6-нд хуралдуулахаар төвлөжээ.

Ц.Мөнх-Оргил сайд хоёр хөршид хийсэн айлчлалынхаа үр дүнг тайлагнаа.

УИХ дахь Ардчилсан намын бүлэг өнөөдөр өргөтгөсөн хуралдаан хийнэ.

Үндсэн хуульд өөрчлөлт оруулахад НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс тусалцаа авна.

Ардчилсан намын орон тооны нарийн бичгийн даргаар О.Магнайг томилжээ.

ЭДИЙН ЗАСАГ

"Сүү" хувьцаат компани 2016 онд 502 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллав.

Монголбанк валютын дуудлага худалдаагаар 16 сая ам.доллар банкуудаас худалдаж авлаа.

Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 68 хувийг БНХАУ-тай хийсэн байна.

Хөрөнгийн биржийн индекс 827.80 нэгж болж, 0.01 хувиар өсөв.

Төв банкны нэг долоо хоногтой үнэт цаасны үлдэгдэл 535.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

НИЙГЭМ

Аялал жуулчлалын зориулалтаар 135 иргэнд газар ашиглах эрх олголоо.

Радио, телевизүүдийн үйл ажиллагааг зохицуулах хуулийн төсөл өргөн барив.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 100 гаруй хяналтын камер суурилуулжээ.

Хүүхдийн төлөө зөвлөл хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавихаар боллоо.

ДЭЛХИЙ

Шведийн Стокгольм хотын цагаачдын байранд үймээн дэгдсэн байна.

Хятадад шувууны ханиадны вирус Н7N9-ийн мутацийг илрүүлжээ.

Их Британид хийх Трампын айлчлалыг эсэргүүцсэн бичигт 1.8 сая хүн гарын үсгээ зурав.

Ираны нефть олборлолтын хотуудыг элсэн шуурга бүрхэж, цахилгаан тасарлаа.

Вануату хэмээх арлын улс чихэр, жигнэмэг, гоймон зэргийг импортлохоос татгалзав.

Өсөлт авчрах мөнгөний чимээ



"Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" бизнест, сайн болон саарыг дагуулах нь. "Ногоон"-ыг номхотгож, гадаад зах зээл дэх хөрөнгө оруулалтын өртгийг бууруулах нь энэ хөтөлбөрийн зэрэг тал. ▶3

Б.Ганбаяр/ЗГМ



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК



ДЭЛХИЙН АЛЬ Ч УЛСАД ТАНЫ САНХҮҮГИЙН НАЙДВАРТАЙ ТУСЛАХ

Хөгжил дэвшилд хамтдаа

Утас: 1900-1977 | И-мэйл: info@tdbm.mn | Вэб хаяг: www.tdbm.mn
Фэйсбүүк: www.tdbm.mn/facebook | Твиттер: www.tdbm.mn/twitter

ЗГМ: СУРВАЛЖИЛГА

Амьжиргаа дээшлээгүй цагт утаа буурахгүй нь

24.000 төгрөгийн үнэтэй дулаан баригч авахын тулд хүүхдийн мөнгөө хүлээдэг

З.Цэлмэг @tselmegZGM

Нийслэлийн утааны нэгдүгээр бүс буюу агаарын бохирдол хамгийн ихтэй гэх Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хорооны нэгэн өрх түүхий нүүрснээс бүрмөсөн татгалзахаар шийджээ.

Орон нутгаас 2004 онд нүүж ирмэгцээ тус хорооны оршин суугч болсон Н.Батынх хоёр жилийн өмнөөс нойтон аргалыг нүүрсний үртэстэй

хольж, ахуйн хэрэгцээнийхээ түлшийг базааж эхэлсэн байна. Анхны өвөл 7.5x8.5 метрийн хэмжээтэй байшиндаа уг түлшээр боломжийн дулаахан өвөлжсөн аж. Тиймээс өнгөрсөн зун гагнуулж хийлгэсэн хоёр хэвээр түлш үйлдвэрлэж, айл саахалтынхаа 10 гаруй өрхөд нэг портсег нь 70 мянган төгрөгөөр борлуулсан байна.

"Авсан айлууд ам сайтай байгаа. Ялангуяа, өндөр настай хүмүүс зуухандаа хийхэд нүүрс шиг пургихгүй, аргал үнэртээд аятайхан юм. Ирэх өвөл дахиад авна гээд одооноос захиалга өгч байна" хэмээн гэрийн эзэгтэй яриу. Эднийх байшинд зориулсан төслийн зуухтай аж. Түлшнээсээ нэг удаад 6-7 ширхгийг хийхэд 2-3 цаг асна. Хоол, цайгаа ч болгоод авдаг гэнэ.

▶5

УЛС ТӨР

Бизнес эрхлэгчдийн эрх ашгаа хамгаалуулах боломж

Б.Даваатогтох @datoZGM

УИХ-аас өнгөрсөн нэгдүгээр сард Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан юм. 2003 онд баталсан уг хууль нь НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын Олон улсын худалдааны арбитрын тухай загвар хуульд нийцээгүй тул ийнхүү өөрчилсөн. Тэгвэл уг хуулийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдэд

танилцуулах олон улсын бага хурал Төрийн ордонд боллоо. Шинэчлэн баталсан Арбитрын тухай хуулиар олон улсын арбитрын ажиллагаа, дотоодын арбитрын ажиллагааг ялгавартай тогтоож, бүрэлдэхүүний эрх хэмжээг өргөжүүлсэн байна. Мөн байнгын арбитрын дүрмийг талуудын тохиролцсонтой адил үзнэ гэж хуульчилсан нь ач холбогдолтой болсон хэмээн судлаачид үзэж байна.

▶2

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.02.22



-8° -20°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРЖИЛТ
8 ДУГААР НҮҮГЭЭС ҮНШВЭ ҮҮ.



86580001029112 00583

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

MSE ALL

827.8
0.01%

АЛТ

1228.8
0.47%

ЗЭС

6070
1.8%

10-ЧИНГИС БОНД

93.576
5.0%

5-ЧИНГИС БОНД

99.585
1.8%

АМ.ДОЛЛАР

2479.84

ЮАНЬ

360.12

РУБЛЬ

42.85

Улс төр

ХУУЛЬ

Бизнес эрхлэгчдийн эрх ашгаа хамгаалуулах боломж



Б.Ганбаяр / ЗГМФ

Арбитрчдад Эрүүгийн хуулийн хариуцлага ногдуулахаар хуульчилсан

Арбитрын тухай хуулийг шинэчлэхдээ эдийн засаг, бизнестэй холбоотой дагалдах 16 хуульд арбитрын заалт тусгасан нь хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг өргөжүүлж байгаа аж. Арбитрч болон талуудад хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хуульд тусгасан нь цаг үеэ олсон гэж МҮХАУТ-ын дэргэдэх Монголын олон улсын үндэсний арбитрын нарийн бичгийн дарга Ч.Гүнжадгава онцлов.

Тэрбээр “Шүүхийн байгууллагатай харьцуулахад арбитраар шийдүүлэх хэрэг бага байна. Хууль батлагдснаар иргэн, аж ахуй нэгжүүд эдийн засаг бизнестэй холбоотой гэрээ хэлцэлдээ арбитрын хэлэлцээрийг тусгаж эхлэх болов уу. Тэгэхээр шийдвэрлэх хэрэг, маргааны тоо нэмэгдэнэ. Манай танхим олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн 62 арбитрагтай. Хуулиар хэчнээн ч арбитр байгуулж болохоор заасан. Тэгэхээр арбитрын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд шинээр бий болно. Харин олон улсад хүлээн зөвшөө-

рөгдсөн, иргэдийн итгэлийг даах арбитрчаар ажиллах мэргэжлийн хүмүүс Монгол Улсад хангалттай байгаа эсэх нь өөр асуудал. Тиймээс арбитрчдыг мэргэшүүлэх талаар ихээхэн ажил хийх шаардлагатай байгаа. Энэ хуульд тэр шаардлагуудыг тусгаагүй. Цэвэр талуудын сонголтын асуудал болгож үлдээсэн” гэв.

Монголын олон улсын ба үндэсний арбитр 2003-2016 оны хооронд нийтдээ 500 гаруй хэрэг, маргааныг шийдвэрлэжээ. Энэ нь шүүхийн байгууллагатай харьцуулахад бага үзүүлэлт аж. Өмнө нь эдийн засаг, бизнестэй холбоотой маргааныг шүүхээр шийдүүлэх ганцхан сонголт байсан бол дагалдах 16 хуульд

Маргалдаж талууд эцсийн шийдвэрт сэтгэгдэл өндөр байдаг

арбитраар шийдүүлж болох сонголт оруулсан байна.

Харин Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт “Бизнесийн харилцааны оролцогчид хүсэл зоригийн дагуу гэрээ хэлэлцээрээ байгуулахын хамт уг гэрээгээс

үүссэн асуудлыг шийдвэрлэх субъект, шийдвэрлэх журам, хэрэглэх хууль тогтоомжийг өөрсдөө тодорхойлох эрх зүйн боломжийг энэ хуулиар бүрэн олголоо. Энэ нөхцөл байдал нь манай улсын арбитрын үйл ажиллагаа дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандартад бүрэн нийцэж байгааг харуулж байгаа юм.

Ингэснээр зөвхөн дотоодын төдийгүй бусад орны бизнес эрхлэгчид өөрсдийн эрх, ашиг сонирхлоо баталгаатай хамгаалуулах эрх зүйн орчныг энэхүү хуулиар бүрдүүлсэн. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалт, компанийн үйл ажиллагаа эрхлэх, бизнесийн аливаа гэрээ хэлцэл хийх, түүнээс үүсэх сөрөг үр дагаврыг арилгах зэрэг асуудлыг нийтийн худалдааны нийтлэг жишгийн дагуу зохион байгуулах боломжтой болсон юм. Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа арбитраг итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлж, маргаан шийдвэрлэх арга болгон сонгох явдал нэмэгдэх эерэг үр дагавар бий болно гэж үзэж байна. Эрх зүйн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг олон улсын стандартад нийцүүлэн зохицуулах нь энэ хуулийн гол онцлог” гэдгийг тодотгосон юм.

Л.БААСАН: АРБИТР МАРГААНЫГ ШУУРХАЙ ШИЙДДЭГ



Энэ үеэр Монголын олон улсын ба үндэсний арбитрын арбитраг Л.Баасангаас дараах зүйлийг тодрууллаа.

–Арбитраар маргаан шийдүүлэхийн давуу тал нь юу вэ?

–Түншлэгч талууд санал зөрөлдөж байгаа зүйл дээрээ тохиролцоод гуравдагч этгээд буюу арбитраар маргаанаа шийдүүлдэг. Мөн арбитр маргааныг шийдүүлж шийддэг. Шүүхийн байгууллага шиг олон шат дамжлага байхгүй. Маргалдаж буй талууд эцсийн шийдвэрт сэтгэгдэл өндөр байдаг. Учир нь өнөөдөр гэрээ байгуулж, маргаан шийдэх арбитраа сонгодог.

Өөрөөр хэлбэл, хэлэлцээрийн үр дүн бол арбитрын шийдвэр байдаг. Нөгөөтэйгүүр, арбитрын шийдвэрт төр оролцдоггүй учир давуу талтай.

–2003 онд батлагдсан Арбитрын тухай хуульд шинэчилсэн найруулга хийж, баталлаа. Энэхүү хуулийн онцлог шинжүүд нь юу вэ?

–Энэхүү хууль Монгол Улсад бизнесийн харилцааг хөгжүүлэх, ялангуяа аж ахуйн нэгжүүдийн маргаан шийдвэрлэх чухал ач холбогдолтой. Хуулийн онцлог шинжийг эрдэмтэн судлаачид олон янзаар тайлбарлаж байна. Миний хувьд энэ удаагийн хууль холбоотой маргааныг бүрэн нийцэж чадсан хэмээн дүгнэж байгаа. Хуулийн тайлбар номыг ч гаргасан байгаа. Тиймээс бизнес эрхлэгчид энэхүү гарын авлагатай бүрэн танилцах хэрэгтэй. Маргаанаа бүрэн шийдүүлэх нь Монгол Улсын нэр хүнд болон бизнесийн үр ашгийг чухал ач холбогдолтой.

–Монголчууд арбитрын шүүхэд хандах хандлага нь ямар түвшинд байгаа вэ?

–Сүүлийн жилүүдэд арбитрын тухай ойлголт ард иргэдийн дунд түгээмэл болсон байна. Арбитрын шүүхэд хандах хандлага ч нэмэгдсэн. Тухайлбал, дөрвөн жилийн өмнө жилийн хугацаанд 30-40 маргааныг арбитрын шүүхээр хэлэлцдэг байсан бол өнөөдрийн байдлаар 100 орчим маргааныг хянаж байна. [ЗГМ]

ЭШЛЭЛ



–Засгийн газар маш хүнд нөхцөлд ажиллаж байгаа. Энэ хугацаанд маш олон мэдээлэл ил тод болсон. Санхүүгийн сахилга батгүй, бодлогогүй, үр ашиггүй, үрэлгэн явж ирсэн нь ил болчихлоо. Өнөөдөр хоолойд тулаад буй хямрал, ханшийн уналт, өр зээлийн асуудал дээр илүү тод харагдаж байна. Ард түмэн үүнийг мэдэрч МАН-ыг олонхи болгосон. Нэг талдаа их итгэл мэт боловч нөгөө талдаа маш том хариуцлагыг үүрүүлчихсэн юм. Нэхэл хатуу даалгавар гэж ойлгож болно.

Засгийн газар эдийн засгийн уналтыг зогсоох эхний алхмаа хийж байна. Бүх боломжоо дайчилж байна. УИХ дахь МАН-ын бүлэг, Байнгын хороод гээд бүхий л түвшинд бид дэмжлэг үзүүлж байгаа. Аль болох хурдан шуурхай ажиллаж, шийдэмгий, хурдтай байхыг хүсэж, шаардаж, шахаж зарим зүйлд нь шүүмжлэлтэй хандаж байгаа нь үнэн.

УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр



–ОУВС-гийн тавьсан шалгуурын дагуу алдагдлаа бууруулах нь чухал. Тодотгол хийх шаардлага, боломж ч байгаа. 2017 оны төсөв батлах үед төсөвт дахин тодотгол хийхээс өөр аргагүй юм байна гэж харж байсан. Харин азаар Эдийн засгийн ил тод байдал, НӨАТ-ын урамшууллын систем зэргээс шалтгаалан орлого бага зэрэг нэмэгдсэн байсан.

Татвар нэмснээр бас нэг сөрөг үзэгдэл гарч болзошгүй. Тэр нь бүх хүмүүс орлогоо нууж эхэлдэг. ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд хадгаламжийн хүүгээс татвар авахаар болж байна. Энэ нь нөгөө хүмүүсийг хадгаламжаа багасгах, хуваах нөхцөл рүү оруулж болох юм. Энэ хэцүү үед татваруудыг нэмэх нь тийм сайн гарц гэж харахгүй байна. ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдсанаар хичээлээ муу хийдэг хүүхдийг хажуу талаас нь ингэж бич гэж зааж байгаатай адил дөрвөн жил явах байх.

УИХ-ын гишүүн асан С.Дэмбэрэл

ТОВЧХОН

» АЙЛЧЛАЛ

Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргилын БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлал өндөрлөлөө. Айлчлалын үеэр тэрбээр тус улсын Гадаад хэргийн сайд Ван И-тэй албан ёсны хэлэлцээр хийлээ. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдыг БНХАУ-д айлчлуулах, Парламент хоорондын байнгын уулзалтын механизмын хоёр дахь уулзалт, Эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын зөвлөлийн анхдугаар хуралдааныг ойрын үед зохион байгуулахаар тохиролцов.

» ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ц.Жамбалдорж Сан Марино улсын Төрийн тэргүүн Марио Рикарди, Фабио Берарди нарт Итгэмжлэх жуух бичгээ барив. Энэ онд Монгол, Сан Мариногийн хувьд дипломат харилцаа тогтоосны 10 жилийн ой тохиож буй аж.

» УУЛЗАЛТ

Монгол Улсын Гадаад харилцааны яам, Япон улсын Гадаад хэргийн яам хоорондын ээлжит Стратегийн зөвлөлдөх уулзалт өнгөрсөн мягмар гарагт Улаанбаатар хотноо боллоо. Уулзалтаар талууд Монгол, Японы Стратегийн түншлэлийн харилцааны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, цаашдын зорилтуудын талаар санал солилцлоо.

» БҮЛЭГ

Олон улсын валютын сангийн Монгол Улсын Засгийн газартай хийж буй хэлэлцээр өндөрлөсөн. Тэгвэл УИХ дахь Ардчилсан намын бүлэг өнөөдөр өргөтгөсөн хуралдаан хийж, 440 орчим сая ам.долларын санхүүжилтийг ОУВС-гаас манай улсад олгохоор болсон асуудлыг хэлэлцэхээр болжээ.

» ТОМИЛОЛТ

Шадар сайд У.Хүрэлсүх тэргүүтэй албаны хүмүүс Баян-Өлгий, Увс аймагт ажиллаж байна. Шадар сайд өвөлжилт хүндэрсэн Баян-Өлгий аймгийн Булган, Сагсай сумын малчидтай уулзаж, нөхцөл байдалтай нь танилцаж, Улсын нөөцөөс өссөн өвс, тэжээл болон хэрэгцээт бараа материалыг хүлээлгэн өглөө. Мөн Эрүүл мэндийн байгууллагад эмнэлгийн автомашин хүлээлгэн өгчээ.

» НАМУУД

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дарга асан О.Магнай Ардчилсан намын нарийн бичгийн дарга болжээ. Ардчилсан намын дарга С.Эрдэнэ тушаал гаргаж, Ардчилсан намын Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан орон тооны нарийн бичгийн даргаар О.Магнайг томилсон байна.

» ПАРЛАМЕНТ

“Төрийн мэдээлэл” хууль тогтоомжийн эмхэтгэлийн шинэ дугаар хэвлэгджээ. Энэ удаагийн дугаарт Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг нийтэллээ. Мөн Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг нийтэлсэн байна.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» OPED@ZASAG.CO

Утас: 99901526 хаяагар бидэнтэй холбогдоно уу.



НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

ДИЗАЙНЕР:

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Мэргэжлийн чиглэлээр их дээд сургууль төгссөн
- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай
- Photoshop, Corel Draw, InDesign, Illustrator болон бусад мэргэжлийн программууд дээр ажиллах чадвартай
- Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй

ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД:

- Бүтээлч сэтгэлгээтэй, шинийг санаачлагч
- Хариуцлагатай
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэл эрмэлзэлтэй
- Ажлын ачаалал даах чадвартай
- Хувийн зохион байгуулалт, цагийн менежмент сайтай

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

- Ажилд орохыг хүсэгчийн анкет
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээний хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхний хуулбар
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын хугацаанд авахуулсан байх)
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Өргөдлийг “Засгийн газрын мэдээ сонин”-ны байранд ирж бөглөх болон baasan.b@zasag.co н-мэйл хаягаар явуулна уу. Утас: 7010-3131

Нийтлэлчийн булан

Өсөлт авчрах мөнгөний чимээ

Монгол Улс ирэх жилүүдэд ямар замаар замнах нь тодорч эхэллээ

Г.Байгал
@baigalZGM

Айдаст автуулж, талцалд татан оруулсан халуун сэдвүүд өвлийн жихүүн өдрүүдийг “дулаацуулж” буй. Санхүүгийн сахилга бат тулгасан ОУВС-гийн нөхцөл ядарсан эдийн засгаа арай ядан чирж яваа хувийн хэвшилд хэрхэн нөлөөлөхийг хэдэн талаас хэлэлцэж байна. Нэг хэсэг нь энэ хатуу шаардлага баялаг бүтээгчдийг элгээр нь хэвтүүлж, хамраар нь газар хатуулаа хэмээн шивнэж байхад, нөгөө нь шил шилээ дарсан шинэ мөнгөний чимээ хувийн хэвшилд гэгээ татуулаа хэмээн уужирч сууна. Монголд тулгаж буй шинэ шаардлага баялаг, балгийн алийг нь дагуулахыг тааж хэлэхэд одоогоор нэн эрт. Гэвч галт тэрэг хөдөлж, Монголын Засгийн газар, ОУВС хэдийн хэлэлцээрийн ширээний ард суусан тул тохиролцооноос буцахад оройтсон ч байж мэднэ. Хариуцлага хүлээсэн хэргүү алхам он дамнан, засаг дамжин сунжирсан ч сая нэг шийдэлд хүрлээ. Тэд Монгол Улсад “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжүүлэхээ зарлав.

ХУВИЙН ХЭВШИЛД ХАЛТАЙ ЖИЛ БОЛОХ УУ

Тэгвэл энэ хөтөлбөр Монголын эдийн засгийн өсөлтийн тулах цэг болсон бизнесийн салбарт хэрхэн нөлөөлөхийг тандья. Шинэ долоо хоногийг ярих сонин хачинтай эхлүүлсэн мэдэгдэлд анхаарлаа хандуулахаас аргагүй. Монгол Улсын Сангийн сайд, төв банкны тэргүүн, ОУВС-гийн төлөөлөгч оролцсон энэхүү мэдэгдлээс Монголбанкны ерөнхийлөгч Н.Баярсайханы хэлсэн үгийг онцолж болмоор. Тэд энэ үеэр ирэх жилүүдийн мөнгөний бодлогын өнгийг тодорхойлоо. “Төв банк зөвхөн мөнгөний бодлого хэрэгжүүлэхэд анхаарна. Өмнө нь хэрэгжүүлж байсан төсвийн шинжтэй төсөл,



С.Батсайхан / ЗГМ©

арга хэмжээнүүдээ зогсооно. Ингэж мөнгөний бодлогыг хатуу төлөвт барина. Хэрэв эдийн засагт эерэг шинж илэрвэл мөнгөний бодлогоо зөөлрүүлнэ” хэмээн тэрбээр мэдэгдлээ. Мөн ОУВС-гийн Монгол Улсыг хариуцсан Ажлын хэсгийн ахлагч Коши Матай ч мөнгөний бодлогын талаар байр сууриа илэрхийлсэн юм. Ноён Коши Матай “Хөгжлийн банкны тухай хуулийг цэгцэлнэ. Монголбанк зөвхөн мөнгөний бодлогын үндсэн чиглэл болох үнийн тогтвортой байдлыг хангахад анхаарна. Төсөвтэй адилтгах ямар нэгэн үйл ажиллагаанд оролцохгүй. Төв банкны мөнгөний бодлого хатуу байх байр сууринд Монголбанкны удирдлагууд болон ОУВС нэгдэж чадсан” хэмээн мэдэгдсэн юм.

Бие биенийхээ мэдэгдлийг давтаж онцолсон энэ хоёр эрхмийн ярианаас ирэх жилүүдэд мөнгөний бодлого хатуу төлөвт хадгалагдахыг түвэггүй мэдэж болно. Өөрөөр хэлбэл, төв банк өөрийн гол зэвсэг болсон жишиг хүүгээрээ дамжуулан мөнгөний бодлогын амыг татах нь. Ингэснээр хувийн хэвшил санхүүжилт татахад улам ч хүндэрч болзошгүй.

Санхүүжилт татах боломж хумигдахтай зэрэгцээ худалдан авалт буурч магадгүй байгаа. Манай бизнес эрхлэгчдэд төр болон олон нийт гэсэн хоёр гол худалдан авагч бий. Өрхийн орлого буурч, иргэд зарцуулалтаа эрс танаж буйг бид мэднэ. Зэрэгцээд төр ч зардлаа танах шаардлагатай нүүр тулчихаад

байгаа. Дээр, дооргүй зардлаа танаж, нийгмийн халамжаа хазаарлаж буй нь төр төдийгүй иргэдийн худалдан авах чадварыг бууруулж, бизнес эрхлэгчдэд сөргөөр нөлөөлөх нь дамжиггүй.

Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш, эдийн засагч Ж.Дэлгэрсайхан “Валютын сантай хамтарсан хөтөлбөр бизнест хүндээр тусгах эрсдэл бий” хэмээн “Bloomberg” телевизэд өгсөн ярилцлагадаа дурджээ. Үүнээс үзэхэд хөгжлийн хөтөлбөр хувийн хэвшилд халтай байх төлөв бууж байна. Энэ нь уг хөтөлбөрийг бууруулах нэг шалтгаан болоод буй.

Олон улсын зах зээл дэх бондын ханш цойлж эхэллээ

Гэхдээ ОУВС-гийн хөтөлбөр Монгол Улсад тогтвортой байдал авчрах сайн талтайг анзаарав уу. Хамтарсан хөтөлбөрийн сураг дуулдахаас ч өмнө буюу сүүлийн 2-3 жилийн хугацаанд манай бизнес эрхлэгчдийн байдал хүндэрч эхэлснийг тэд учирладаг. Манай компаниуд тэсч үлдэх тактик хэдийн хэрэгжүүлээд эхэлсэн. Хэдхэн жилийн өмнө жилийн 7.5 тэрбум төгрөгийн орлоготой байсан компани өдгөө 700 сая төгрөг ч олж чадахгүй байгаагаа учирладаг.

Зарим нь бүр хэдийнэ үүдээ

бариад эхэлсэн. Өнгөрсөн онд Монголын гэх тодотголтой хоёр компани тутмын нэг нь үүдээ барьсан гашуун мэдээг Үндэсний статистикийн хороо энэ оны эхээр мэдээлэв. 2016 оны эцсийн байдлаар манайд 134 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас 66 мянга нь үйл ажиллагаагаа зогсоожээ. Ийм л баргар байдал бизнест нүүрлээд буй тул хөтөлбөр хэрэгжүүлэхээс яах билээ.

ШИНЭ МӨНГӨНИЙ САЙН ЧИМЭЭ

Саараас гадна сайныг дагуулж байгаа нь бидний сонгосон зам. Бизнес эрхлэгчид үр ашгийг зардлаа танаж, оновчтой бүтцээр ажиллаж сурьныгаа олзуурхдаг. Санхүүгийн эдийн засгийн их сургуулийн багш, доктор Д.Гэрэлмаа “Эдийн засгийн энэ хүнд байдал нь бизнес эрхлэгчдэд зөв почроо өгсөн. Макро эдийн засгийн хүндрэл бизнес эрхлэгчдэд сорилтоо боломж болгон харахад хүчтэй нөлөөлжээ. Тиймээс тэд үйл ажиллагаагаа илүү цомхон, оновчтой болгосон нь анзаарагдаж байна. Мөн үйл ажиллагаагаа экспортод чиглүүлж байна. Аль болох дэлхийн зах зээлд гарах гэж хичээдэг болсон” хэмээн ярилаа.

Үүнтэй зэрэгцээд Засгийн газрын болон Олон улсын валютын сан бодлогын тодорхой байдлыг амлаад байна. Тогтвортой бус, тодорхойгүй байдал Монголын хорт хавдар хэмээн гадаад, дотоодын шинжээчид хэлдэг. Тэгвэл Монгол Улс ирэх жилүүдэд ямар замаар замнах

Долларын ноёрхол дуусч, төгрөгийн уналт төгсөх цаг ирлээ. Итгэхгүй бол төв банкны төгрөгийн албан ханшийн муруйг тогтож хараарай.

Монгол Улсын Засгийн газрын таван жилийн хугацаатай Чингис бондын ханш даваа гарагийн байдлаар 1.9 хувиар өсөж, 100 нэгжийг шүргэж байна. Ингээд зогсохгүй хөгжиж буй орнуудын бондын өсөлтийг Монголын бондууд хошуулчилсныг “Reuters” уламжлав.

Хөрөнгө оруулагчид Монголыг алга ташин хүлээн авч буй нь энэ. Шинэ мөнгөний мэдээ зөвхөн ханшийн муруйг өсгөөд зогсохгүй нь. Манай улс цаашлаад Монголын гэх тодотголтой бизнес эрхлэгчид хилийн чанадаас хөрөнгө оруулагч татахад эерэг нөлөө үзүүлнэ. Ийм жишээ олон улсад цөөнгүй бий. Одоогоос дөрвөн жилийн өмнөөс ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн Ямайк улсыг жишээ болгоё. Тус улсын бизнесийн салбар энэ хэдэн жилд сэргэжээ. Тиймээс ВМІ байгууллагаас Ямайкийн бизнесийн салбар хөл дээрээ бат зогссон тул ирэх жилүүдэд эдийн засгийн өсөлтийг тэтгэх хүч болно гэж үзэж байна.

Зарцуулалтаа танана гэдэг хэнд ч амар биш нь ойлгомжтой. Гэхдээ энэ нь эргээд Монголын хэтийн хөгжлийг багтай болгож чадвал нэг, хоёр жилийн таналтгүй даваад гарч болохгүй гэж үү. Өнөөдрийн өөхнөөс маргаашийн уушиг дээр гэдэг үг бий. Эцэст нь Сангийн сайдын арга барсан үгээс эшлэе. “Та бүхэн нэг зүйлийг ойлгох хэрэгтэй. Бид ОУВС-тай хөтөлбөр тохирно гэдэг нь Монгол Улсын эдийн засаг доошоо унахдаа аль хүртэл унах доод шал, доод хил хязгаараа тогтоогоод авч байна. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж чадсан тохиолдолд 2017 оны төгсгөл, ирэх оны эхний улирлуудад хувийн секторын нөхцөл байдал сайжирна. Төр зардлаа багасгаж, хувийн секторыг дэмжих бодлогыг Засгийн газар, Монголбанк, ОУВС дэмжиж байгаа. Энэ хэдий анагаах увдистай ч ууж байх үед гашуун байдаг. Тийм учраас энэ 2017 оныг Монголын ард түмэн, бизнес эрхлэгчид тэвчээрэй. Энэ богинохон хугацаанд эдийн засгийнхаа бүтцийг өөрчилж, санхүү төсвийнхөө сахилга батыг сайжруулж авах шаардлагатай байна гэдгийг учирлаж хэлэхээс өөр аргагүй байна” хэмээснийг ухаарахаас аргагүй. [ЗГМ]

С.ЦОГТБЯАР ЗУРЖ БАЙНА



Эрүүл мэнд

Булчирхай эрүүл байвал өвчин тусахгүй


Г.Сайнзаяа
@sainzayaZGM

Хүний биеийн эсэргүүцэл сулрахад тунгалгийн булчирхай үүнтэй тэмцэж, дархлааг дэмжиж байдаг. Товчхон хэлбэл, дархлааны эрхтэн юм. Тунгалгийн булчирхай нь цусны системтэй маш ойр буюу судас даган байрлах ба уг системийн тэжээгч гэж хэлж болно. Хүний биеэс хорт бодисыг гадагшлуулдаг цогц тогтолцоо гэсэн үг. Уг булчирхай нь хүний биеийг гаднын нөлөөтэй халдвар авах, илүүдэл шингэн хуримтлагдах, таргалах болон биед хорт бодис тархах зэрэгтэй тэмцэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг байна.

Тийм ч учраас малын эмч нар хүнсэнд хэрэглэх малын эрүүл мэндийг шалгахдаа булчирхайн үйл ажиллагааг зайлшгүй харгалздаг. Тэр дундаа тунгалгийн булчирхай өвчилсөн бол шаардлага хангахгүй гэж үздэг байна. Энэ булчирхай ямар чухал үүрэгтэй болох нь эндээс харагдах байх.

Манайд тунгалгийн булчирхайн үрэвслийн талаарх хамгийн сүүлийн судалгааг 1993-2000 онд хийсэн. Ер нь энэ талаар мэргэжлийн эмч нар ч ойлголт муутай байдгийг салбарынхан хэлж байв. Судалгааны үед ч, түүнээс хойш ч хэвтэн эмчлүүлж байгаа хүүхдийн 40 орчим хувь нь энэ төрлийн үрэвсэлтэй байж. Судалгаагаар энэ өвчин хүүхдүүдэд харьцангуй элбэг тохиолддог гэсэн дүгнэлтэд хүрээд буй. Гол шалтгаан нь хүүзүү, нүүр, эрүү орчмын байрлалтай архаг үрэвсэл байдаг аж. Тухайлбал, хоолой байнга өвдөх, чихнээс булаг

Тунгалгийн булчирхай цочиж, үрэвсэхэд өрхийн эмч нар гахайн хавдартай эндүүрэх нь бий. Нөгөөтэйгүүр эцэг, эхчүүд эмчид хандалгүй таамгаар оношилж, буруу эмчилгээ хийдэг.



Шүд хорхойтвол тунгалгийн булчирхай өвчилнө

Хүний биед 501-700 тунгалгийн булчирхай байдаг бөгөөд тал нь хооноод, бүдүүн гэдэс орчимд байрлана. Суга орчимд гэхэд л 100 орчим нь байдаг бөгөөд хөлс, нус, өтгөн, шингэн, шүлс зэргээр гадагшилж, шүүгдэж байдаг.

Тунгалгийн булчирхайд асар их хэмжээний инестин агуулагдана. Энэ нь биеийн дархлааг сайжруулан, хүний биед агуулагддаг ашигтай нэгдлүүдийг ашиггүйгээс нь зааглан, хөгшрөлтөөс сэргийлдэг ажээ.

Хөдөлгөөний дутагдал, идэвх дутмагшил, элдэв өвчлөл болон хоол боловсруулах системийн доголдол зэрэг нь тунгалгийн булчирхайн хэвийн үйл ажиллагааг гацааж, улмаар бие өвчлөхөд хүргэдэг. Малын тунгалгийн булчирхай ч мөн ижил үүрэг гүйцэтгэдэг.

гоожих нөлөөлнө. Мөн шүд цоорох, буйл үрэвсэснээс болж эрүү, нүүрний булчирхайнууд цочдог. Тунгалгийн булчирхай цочиж үрэвсэхэд өрхийн эмч нар гахайн хавдартай эндүүрэх нь бий. Нөгөөтэйгүүр эцэг, эхчүүд эмчид хандалгүй таамгаар оношилж буруу эмчилгээ хийдэг. Ингэснээр булчирхайг улам үрэвсүүлж, хүндрүүлдэг аж. Эрт оношилсон тохиолдолд эм, физик эмчилгээгээр эмчлэх боломжтой. Харин хожуу оношилж, цаг алдсанаас идээ бээр биеэр тарсан бол мэс засал зайлшгүй хийлгэдэг юм байна.

Эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ цоорсон шүдийг эмчлүүлэх, хоолойн махыг нь авахуулах зэрэг суурь өвчнийг нь устгавал өвчлөхгүй байх боломжтой аж. Үүгээр ихэвчлэн 0-5 насныхан өвчилдөг. Учир

нь хүүхэд төрөхдөө дархлааны систем нь сайн хөгжөөгүй байдаг.

Манайд ихэвчлэн 0-5 насныхан өвчилдөг

Таван нас хүрэхэд хангалттай хөгжиж дуусдаг тул тэр хүртэл жилд хэд хэдэн удаа ханиад хүрч, суулгахыг барууны анагаах ухаанд хэвийн гэж үздэг ажээ. Дархлаа муудсан үед хүүхдийн биед вирус эмчлүүлэх, хоолойн антибиотикоор дарах боломжгүй болдог гэж зарим эмч үзэж байна. Харин барууны орнуудад өсвөр насны хүүхдүүд энэ өвчинд гол төлөв

өртдөг байна. Энэ нь үнсэлцэх үед шүлсээр халдвар, вирус авах болон аяга халбага солих зэрэг олон шалтгаантай ажээ. Яг өсвөр насны охино ийм өвчнөөр өвчилснийг мэдээд эмчлүүлсэн Г.И гэгч эмэгтэй хүүхдээ өвчнөөс хэрхэн ангижруулсан түүхээ хуваалцсан юм. Тэрбээр “Монголд тунгалгийн булчирхайн үрэвсэл гэж оношилсон ч зайлшгүй хагалгаа хийлгэх хэрэгтэй гэсэн. Би үүнтэй санал нийлээгүй тул

охиноо аваад Бээжинд очиж үзүүлэхэд хүчтэй антибиотик уулгаж, эдгээсэн. Булчирхай мэс засалд их эмзэг, мэс хүргэж болдоггүй гэж сонссон учраас хагалгаа хийлгэх эмч нарын саналыг хүлээж аваагүй” гэв. Мэс заслын дараах ариун цэврийг сахиагүй, шаардлагатай эмчилгээ хийлгээгүй тохиолдолд өвчин дахих магадлалтай байдаг ажээ.

Дархлалын тогтолцоо тунгалгийн булчирхайн үйл

ажиллагааг өөртөө нэгтгэж явдаг бөгөөд энэ нь бие махбодийг халдвараас хамгаалах гол хэрэгсэл болдог. Тунгалгийн тогтолцооны идэвхтэй үйл ажиллагааны дүнд биеийн эсүүдийн завсраас шингэн ялгарч, хуримтлагдан гадагшилдаг. Энэ мэт нарийн үйл явц дундаа тунгалгийн булчирхайнууд нь хүний бие махбодод гаднаас орсон бактери, хорт зүйлүүдийг устгах чадалтай ажээ. [31]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шуудага ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбатын ДОЛГИОН

Тэргүүн орлогч эрхлэгч
Цэвээндолгорын ЦЭВЭЭНХЭРЛЭН
Утас: 99901526

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртотгох
Утас: 99901532

Гадаад контент, соёл интертейнментын алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Г.Лхагвасүрэн
Утас: 99903581

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

Zasag.Co
“Чөлөөт хэвлэл”
сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв

Дугаарын удирдагч
Г.Баярсайхан

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Д витаминьг нэг дор ихээр хэрэглэхгүй байхыг анхааруулав

Монголчуудын 99 хувь нь Д аминдэмийн дутагдалтай талаар сүүлийн үед их яригдах боллоо. Энэ далимаар зарим байгууллага, эмнэлэг бизнес хийж, иргэдийн халааснаас мөнгө шамшигдуулах явдал гаарч байгааг эмч нар анхааруулав.

Харвардын анагаах ухааны их сургууль, Харвардын нийгмийн эрүүл мэндийн их сургуулийн багш, дэд профессор Д.Ганмаа сүүлийн 12 жилийн турш монголчуудад зонхилон тохиолддог өвчлөлийн эсрэг Д аминдэмийн талаар судалгаа хийсэн. Үүнээс харвал Монгол Улс хойд өргөргийн 48 хэмд байрладаг тул нарны тусгал газрын гадаргууд шууд биш, ташуу байдлаар тусдаг. Иймээс монголчуудын арьсан дахь Д аминдэмийн нийлэгжилт хангалтгүй байна. Даминдэмийн хагас задрах хугацаа дунджаар хоёр долоо хоног. Тиймээс сард нэг удаа өндөр тунгаар уух нь хангалтгүй. Мөн хот, хөдөөгийн иргэдийн Д аминдэмийн хэмжээг шинжилж үзэхэд байх ёстой хэмжээнээс 2-3 дахин бага гарчээ.

Энэхүү мэдээллийн сургаар Д аминдэмийн дутагдлыг хэмжих, нэг дор их тунгаар уулгах, тарих үйлчилгээ, бүр багц хүртэл гараад буй. Борооны дараах мөөг шиг олширсон эдгээр бизнес хүний эрүүл мэндэд туйлын анхаарч ингэвс үү гэвэл үгүй. Д.Ганмаа профессор энэхүү аминдэмийн хүн насан туршдаа уух хэрэгтэй гэсэн. Түүний ярилцлагаас эш татвал “Насанд хүрсэн хүн өөрөө өдөр болгон витамин ууж болох ч хүүхдүүдэд өдөр болгон витамин тараана гэдэг хүн хүч,

нөөц бололцоо асар их шаардсан хүндрэлтэй ажил. Тиймээс сард нэг удаа өндөр тунтай Д аминдэм хүүхдүүдэд өгөөд дутагдлаас нь гаргаж чадах нь уу гэдгийг давхар харьцуулсан судалгаа хийсэн юм. Д аминдэмийн хагас задралын хугацаа нь дунджаар хоёр долоо хоног байдаг тул хэчнээн өндөр тунтай уулаа ч үүний дараа авсан Д нь задраад алга болчихдог юм байна. Тэгэхээр бид сард нэг удаа хүүхдэд Д өгчихөд болчихлоо гэж үзэж байвал энэ нь хангалтгүй. Үүнээс үндэслэн Д аминдэмийг өдөр тутамд шаардагдах физиологийн тунгаар байнга хэрэглэх нь хүн эрүүл байх, дархлааны хэвийн үйл ажиллагааг хангах үндэс болдог” гэжээ.

Д аминдэмийг нэг дор уух нь үр дүнгүй

Ингээд өндөр тунгаар, нэг дор нь уулгаж, бүр тарьж байгаа нь хогийн сав руу мөнгө чулуудаж байгаагаас өөрцгүй юм байна. Бусдын олон жилийн судалгаа, хөдөлмөрийг ашиглан мөнгө олж байгаа эмнэлгүүдэд бурууг тохохоос илүүтэй иргэдэд мэдлэг олгох нь чухал. Өндөр үнэтэй багц үйлчилгээ монголчуудыг Д аминдэмийн дутагдлаас гаргахгүй. Сураг сонсож, айдаст автан бизнесийн эх үүсвэр болохын оронд тууштай, зохистой хэрэглээг сурах шаардлагатайг эмч нар хэллээ. [31]

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

Ажлын байрны үндсэн зорилго: Сонины маркетинг, борлуулалтыг шууд хариуцан ажиллах ба тус чиглэлээр судалгаа хийж, нарийвчилсан төлөвлөгөө гаргах, мөн сонинд байрших сурталчилгааны урсгалыг тогтмол нэмэгдүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

- Харилцагчийн сурталчилгааг хянаж, тухайн өдрийн дугаар удирдагчдад эцсийн байдлаар хүлээлгэн өгөх
- Сурталчилгааны борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр байнгын харилцагчдын хүрээллийг тогтмол тэлэх
- Сонины танилцуулга бэлтгэх, уулзалт зохион байгуулах

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Бизнесийн удирдлага, маркетингийн мэргэжилтэй байх
- Борлуулалтын чиглэлээр 2-оос доошгүй хугацаанд ажиллаж байсан туршлагатай
- Гэрээ хэлэлцээр хийх, гэрээ, албан бичиг боловсруулах, танилцуулах чадвартай
- Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

- Компьютерын хэрэглээний программуудыг эзэмшсэн
- Хувийн зохион байгуулалт, ажилдаа хариуцлагатай ханддаг, цаг ашиглалт сайтай байх
- Бусдыг удирдах зохион байгуулах, манлайлах ур чадвартай, бүтээлч, шинийг санаачлагч
- Ажил хэрэгч, харилцааны соёлтой байх
- Удаан хугацаанд ажиллах хүсэл эрмэлзэлтэй байх

СЭТГҮҮЛЭГ:

Ажлын байрны үндсэн зорилго: Редакцнаас өгсөн чиглэл, төлөвлөгөөний дагуу мэдээ бэлтгэх, сурвалжлага хийх, ярилцлага авах, нийтлэл бичих төдийгүй өглөөний шуурхайд мэдээ танилцуулах үүрэг гүйцэтгэнэ.

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

- Хариуцсан салбарын гол мэдээлэл, сурвалжлагыг цаг алдалгүй сурвалжлан бэлтгэх, нийтлэх
- Хариуцсан салбараа гүнзгийрүүлэн судалж, мэргэшиж ажиллах
- Сэтгүүл зүйн үндсэн зарчим, шаардлагыг хангасан, эх сурвалжаар баталгаажсан, бодит мэдээ мэдээллийг уншигчдад цаг алдалгүй хүргэхэд анхаарах

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Сэтгүүл зүй, хэл шинжлэлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн
- Олон улсын харилцаа, нийгэм эдийн засаг, улс төрийн талаар мэдлэгтэй
- Монгол хэлний яриа, бичгийн дүрмийн мэдлэг, найруулан бичих чадвар шаардсан ажил хийж байсан туршлагатай.
- Мэргэжлийн ёс зүйтэй
- Судалгаа шинжилгээ хийх, мэдээллийг цуглуулах, үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

- Гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй
- Оффисын хэрэглээний программууд дээр чөлөөтэй ажилладаг байх
- Хувийн зохион байгуулалт, ажилдаа хариуцлагатай ханддаг, цаг ашиглалт сайтай байх
- Бусдыг удирдах зохион байгуулах, манлайлах ур чадвартай, бүтээлч, шинийг санаачлагч
- Удаан хугацаанд ажиллах хүсэл эрмэлзэлтэй байх.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл, анкет
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээ, Их дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхийн хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байх
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын дотор авахуулсан)
- Оршин суугаа хагяийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Анкетыг “Засгийн газрын мэдээ сонин” ХМХ-ийн байранд ирж бөглөх бөгөөд бүрдүүлэх материалыг хүлээлгэн өгнө үү.

Холбоо барих утас: 70103131

Хаяг: Блю Скай тауэр, 4 давхар, № 407, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14240, Монгол улс

ЗГМ: Сурвалжилга

Амьжиргаа дээшлээгүй цагт утаа буурахгүй нь

«Цаашдаа хийх арга боловсронгуй болгож, олноор нь хийхгүй бол энэ их нойтон аргал барагдахгүй нь» хэмээн гэрийн эзэн хашааны нэг буланг тэр чигт нь эзэлсэн овоолоостой хур аргал руу заав.

Эдний хороо 60 гаруй малчин өрхтэй. Н.Батынхтай адил нойтон аргалыг модны үргэстэй зуураад тулшээ базаадаг айл мэр сэр бийг хорооны Засаг дарга Л.Төмөрбаатар яриу. Улаанчулуутын хогийн цэгтэй баруун урд хэсгээрээ хиллэдэг энэ хороо нийт 4000 гаруй өрхтэй. Бүгд зуух галлаж амьдардаг байна. Амьжиргааны түвшин нэлээд доогуур. Ялангуяа, Улаанчулуут хавиар амьдардаг айллууд пүүз, дугуй гэх мэт хоёрдогч түүхий эд шатаах нь их тул байнга хяналт тавихаас аргагүйд хүрдэг аж.

УТААГҮЙ ЗУУХЫГ ИЙШ ТИЙШ ТАРААГААГҮЙ

Дөрвөн жилийн өмнө тус хорооны бараг ихэнх өрх утаагүй буюу төслийн зуух авчээ. “Төслийн зуухыг хөдөө гадаа зарж үрсэн, идэш тэжээлд үрэлж гэх яриа их гарсан. Танайд байдал ямар байгаа бол” гэж асуухад “Манай энэ хавиар зуухаа хөдөө гаргасан айл байхгүй. Маркаар нь шалгаж байгаа шүү дээ” хэмээн Л.Төмөрбаатар тайлбарлав. Хамгийн гол нь энэ зууханд түлэх зориулалтын түлш байхгүй, байсан ч иргэдэд тэр бүр хүрэхгүй тул утаагүй зуухны ашиг тус гараагүйг тэрбээр нэмж онцолсон юм.

Бид энэ хорооноос гараад СХД-ийн 7 дугаар хороог зорив. Зүүн болон Баруун салааны уулзварт, хонхор газар байрладаг учраас тус хорооны агаарын чанарын индекс хамгийн өндөр буюу гадаад орчинд гарахгүй байхыг зөвлөх хэмжээний түвшинд хүрдэг. Хорооны Засаг дарга Н.Оюунчимэгтэй уулзахаар өрөөнд нь орвол өрхүүдийг зах зээлийн судалгаанд хамруулсан асуулга хурлын ширээн дээр нь тарсан байлаа. Ихэнх нь “Сарын орлогын хэмжээ 150 мянга хүртэл, 150-300 мянга” гэснийг нь дугуйлсан харагдана. “Манай хороонд гэр хорооллын 4661 өрх бий. Үүнээс 60 гаруй өрх л дулаанаа цахилгаанаар шийдэж байна. Бусад нь төслийн зуухаа галлаж байгаа. Утааг бууруулахад иргэдийн оролцоо үнэхээр хэрэгтэй байна” гэсээр бидний яриа эхлэв.

ҮР ДҮНГҮЙ ТӨСЛҮҮД

Н.Оюунчимэг дарга агаарын бохирдлыг бууруулах ямар ч ажил эхлүүлсэн үр дүн нь иргэдийн амьжиргааны түвшнээ шууд шалтгаалахыг илтгэх хэд хэдэн баримт дэлгэцээ. Саяхан дулаан баригч төхөөрөмж борлуулах төслийг нэгэн хувийн байгууллагаас хэрэгжүүлжээ. Түлшний зарцуулалтыг багасгахын зэрэгцээ дулаанаа зургаан цаг барьдаг, 40 мянган төгрөгийн үнэтэй төхөөрөмжийг 24 мянган төгрөгөөр борлуулахаар болсон байна. Төхөөрөмжийг 235 өрхөд үнэгүй тарааж, үлдсэнтэй нь тооцоо хийх гэтэл хүүхдийн мөнгө, гэтгээр буухаар хийе гэсэн хариу өгчээ. “24 мянган төгрөгийн үнэтэй эдийг худалдаж авч чадахгүй байхад бид үүнээс илүү хямд ямар ажил хэрэгжүүлэх вэ” хэмээн тэрбээр халаглалаа.

Түүнчлэн айл өрхийн дулаан алдагдлыг бууруулах бас нэг ажлыг дүүргийн хэмжээнд эхлүүлэхээр өрхүүдээс судалгаа авч байгаа юм байна. Гол шаардлага нь тухайн байшин бүхэлдээ нэг л төрлийн материалар боссон, суулт өгөөгүй, баригдаад удаагүй байх ёстой аж. Гэтэл гэр хорооллын дийлэнх байшин энэ шаардлагыг хангаж чадахгүй байна. Урьдчилсан

байдлаар судалгаа хийхэд 24 дүгээр хорооны тав, 7 дугаар хорооны найман байшин л арай гэж шалгуурт тэнцжээ. Сонгож авсан байшингаа Цагаан сарын дараа дулаалаад, үр дүн нь ямар байгааг тав, аравдугаар сард шалгах аж. Амжилттай болбол ирэх жил хүйтний улирлаас урьтаж хэрэгжүүлэх юм байна. Төслөөр 6x8 метрийн хэмжээтэй нэг байшин дулаалах үнийг хоёр саяар тооцжээ. Үүний 1.5 саяыг төслийн, 0.5 саяыг тухайн өрхийн санхүүжилтээр босгоно. Гэтэл айлууд мөн л ийм хэмжээний мөнгө гаргаж чадахгүй гэдгээ илэрхийлсэн байна.

4661 өрхийн 60 гаруй нь л дулаанаа цахилгаанаар шийдэж байна

Гэтэл оны өмнө болсон агаарын бохирдлыг бууруулах технологийн үзэсгэлэнгээр хамгийн их сурталчилсан төхөөрөмж нь 2.4 сая төгрөгийн үнэтэй. Шөнө нь дулаанаа хуримтлуулж, өдөр нь түгээдэг тус зуухыг аваад тавьчихвал уг нь шөнийн цахилгааны хэрэглээний хөнгөлөлтийг айл өрхүүд бодитоор эдэлнэ. Харамсалтай нь 24 мянгаар дулаан баригч худалдаж авч чадахгүй байгаа иргэд 2.4 саяар яаж авах вэ гэдэг нь үнэхээр асуудал болоод байгааг иргэдтэй хамгийн ойр ажилладаг, төр захиргааны нэгж хариуцсан дарга Н.Оюунчимэг хэлж байна.

ШИЙДЭЛ НЬ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨНГӨЛӨЛТ БИШ, ОРОН СУУЦ

Цахилгааны шөнийн тарифыг тэглэсэн ч утаа багассангүй. Цэвэр агаараар амьсгалахыг хүссэн иргэдийн бухимдал ч намжихгүй байна. Үүний



С.Батсайхан/ЗГМ©



шалтгааныг агаарын чанарын индекс хамгийн өндөртэй бүсийн Засаг дарга нар бодит амьдралд буухгүй шийдвэр гаргасантай холбож байна. Өөрөөр хэлбэл, ажлаасаа тарж ирээд хоол, цайгаа хийдэг цагт цахилгааны хөнгөлөлт үйлчлэхгүй бол иргэд нүүрсээ түлсээр л байх нь.

Харин эрчим хүчний салбарынхан аюулгүй байдлын үүднээс оргил ачааллын үеийн хэрэглээг хөнгөлж болохгүйг анхааруулж буй. Үнэхээр ч

цахилгааны холболт нь оргил ачааллыг даах чадваргүй, түймэр гарах өндөр эрсдэлтэй байгааг СХД-ийн Онцгой байдлын хэлтсийнхэн шалгаж, илрүүлсэн байна. Хэдийгээр иргэдэд заавар, зөвлөмж өгсөн ч гэр хорооллын цахилгааны шугам, дэд бүтцийг сайжруулах зайлшгүй шаардлагатай. “Өмнө нь төслийн зуухыг буруу галласны улмаас түймэрт автсан эмгэнэлтэй түүх бий. Жоохон юмнаас л гал ноцно шүү дээ” гэж

» Урьдчилсан байдлаар судалгаа хийхэд 24 дүгээр хорооны тав, 7 дугаар хорооны найман байшин л арай гэж шалгуурт тэнцжээ.

» 24 мянгаар дулаан баригч худалдаж авч чадахгүй байгаа иргэд 2.4 саяар яаж авах вэ гэдэг нь үнэхээр асуудал.

» Цахилгааны холболт нь оргил ачааллыг даах чадваргүй, түймэр гарах өндөр эрсдэлтэй байгааг СХД-ийн Онцгой байдлын хэлтсийнхэн шалгаж, илрүүлсэн байна.

Л.Төмөрбаатар анхаарууллаа.

Гэтэл ойрын хэдэн жилд тус хороодын нутаг дэвсгэрт дахин төлөвлөлийн ажил тусгагдаагүй байгаа аж. “Уг нь иргэдийн хамгийн их хүсдэг зүйл нь дахин төлөвлөлт. Одоо байгаа хөрөнгөө төвийн дэд бүтэцтэй холбогдсон, дулаан байраар сольчихвол нүүрс түлэхгүй шүү дээ. Бид Ерөнхийлөгчтэй уулзах үеэрээ дахин төлөвлөлт, орон сууцжуулах хөтөлбөрүүдийг яаж ийгээд урагшлуулаач гэсэн хүсэлт тавьсан” хэмээн Н.Оюунчимэг хэлсэн юм. Эс бөгөөс хот төлөвлөлийн мэргэжилтнүүдийн зөвлөж буйгаар Улаанбаатар хотыг задалж, дагуул хотууд байгуулж байж утаанаас ор мөргүй салах биз ээ.

Н.Батынх шиг нүүрснээсээ татгалзах иргэдийн ухамсар, идэвх зүтгэлээс гадна эдийн засгийн чадавхаас агаарын бохирдол буурах эсэх нь шууд шалтгаална. Үнэндээ улаанбаатарчууд уурлаж жагссан ч урин цагийг утаатайгаа л угтаж байна, энэ жил. [ЗГМ]

Шилдгүүдийг нэг дороос...



Та доорх кодыг уншуулж Засгийн Газрын Мэдээ Financial Times сонинг нэг дороос уншина уу



Та QR code уншуулахын тулд App Store-оос QR reader татаж суулгана уу.

70103131, 99903581, 99903584
info@zasag.co
Zasag.Co



Өв соёл

Угийн бичгээ
хөтлөлгүй 91
жилийг үдэжээГ.Оюунтөгс
@oyuntugsZGM

“Ургаа мэдэхгүй хүн усаа мэдэхгүй малтай адил”, “Ухаан орж ургаа таних”, “Удам холдвол ухаан нэмнэ” гэдэг үгс өвгөдөөс минь өвлөгдсөөр ирсэн нь учиртай. 1924 онд монголчуудын 95 орчим хувь нь ургийн овгоо мэддэг байсан гэдэг. Гэвч социализмын жилүүдэд ургийн овгийг халж хаяснаас хойш бид эцгээрээ овогосоор өдийг хүрчээ. Үүнтэй хамт угийн бичиг хөтлөх гэдэг зүйл бараг мартагдсан гэж хэлж болно. Энэ нь хүн амын дунд цус ойртоход нөлөөлсөн болохыг судалгаагаар тогтоогоод байна. Тухайлбал, үндэсний хэмжээнд 11 системийн 340 гаруй генээр



С.Батсайхан / ЗГМФ

Удам угсааны тайлбар толь
буюу угийн бичиг

удамшлын тархалтыг гаргаж ирсэн байдаг. Судалгааны тооцооллыг тайлбарлавал, олон улсад цус ойртолтыг хэмждэг 0-1-ийн хооронд утга авдаг F коэффициент гэж бий. Хэрэв тэгтэй тэнцүү байвал тухайн хүн амын дунд цус ойртолт байхгүй. Харин нэг рүү дөхөвлөх цус ойртолт байна гэсэн үг. Энэ аргаар Монгол Улсын аймаг болгонд тооцоолол хийхэд тэгтэй тэнцэж байгаа аймаг нэг ч гарсангүй. Өөрөөр хэлбэл, аймаг бүрт гурав, дөрөв дэх үеэ мэдэхгүй, цусан төрлийн хамааралтай үр удамууд хоорондоо гэрлэхэд илэрдэг цус ойртолтын хэлбэр илэрчээ.

Ураг удам, удамшлын талаар судалдаг эрдэмтэн судлаачид үүнийг үндэсний хэмжээний аюул гэж үзэн үндэсний зөвлөлгөөнийг энэ сарын эхээр зохион байгуулсан юм. Зөвлөлгөөний үеэр Монгол ураг удам, уламжлалын холбооны тэргүүн Ж.Түдэвдорж “Угийн бичигтэй болсноор хамаатан саднаа мэдэхгүй цус ойртох жишээлбэл, орчин цагийн монгол хэлэнд ураг төрлийн нэр томъёо 100 гаруй бий. Үүнийг мэдэхгүйгээс болоод миний ахын эхнэрээс гарсан эрэгтэй хүүхэд гэж олон үгээр

болхи ярьдаг. Манай нөхрийн хамгийн бага дүүгийн авгай гэхийн оронд бага ажин, ээжийн төрсөн дүүгийн гэр бүлийн хүн гэхийн оронд нагац бэргэн гэх мэтээр төрөл саднаа зөв үгээр дуудаж, ураг удам мэдэх нь нэн тэргүүнд тавигдах асуудал болжээ” гэсэн юм.

ЦУС ОЙРТОЛТЫН
ДАГУУЛ БУЮУ ОЮУНЫ
ХӨГЖЛИЙН СААТАЛ

Цус ойртох үзэгдэл нь хүн амын дотор олон үе удмын турш үл анзаарагдах байдлаар явагддаг генетик процесс. Генийн сангийнхаа тодорхой хувиар хоорондоо ураг төрлийн холбоотой хүмүүс гэрлэхийг цус ойртсон гэрлэлт гэдэг. Хүн ооноос 2015 оны эхний зургаан сар буюу 1.5 жилийн хугацаанд 1280 хүүхэд гажигтай төрсөн гэсэн судалгаа гарсан байна. Өөрөөр хэлбэл, шинээр төрж байгаа хүүхдийн 0.8 хувь нь гажиг, согогтой байжээ.

Цус ойртолтыг шууд болон алсуур гэж ангилдаг. Шууд нь цусан төрлийн хамаатай хүмүүс хоорондоо гэрлэх, алсуур нь нэг нутаг усны, ойр амьдардаг хүмүүс олон үеэрээ хоорондоо гэрлэх юм.

Харин Монголд цусан төрлийн холбоотой хүмүүс ураг барилдах

нь түгээмэл үзэгдэл болсонд эрдэмтэд санаа зовниж байна. Цус ойртолтыг сүүдэр мэт дагаж явдаг нэг зүйл бол оюуны хомсдол, оюуны хөгжлийн саатал юм. Амьгүй төрөлт, зулбалт их болж байгаа нь бүгд цус ойртолтын илрэл бөгөөд биеийн дархлаа суларч, өвчин эсэргүүцэх чадвар нь доройтдог аж.

Гэтэл сүүлийн үед хүн амын дунд эдгээр шинж тэмдэг тод илэрч байна. Тухайлбал, ЭХЭМҮТ-ийн мэдээлснээр 2005-2009 он хүртэлх дөрвөн жил хагасын хугацаанд улсын хэмжээнд 689 хүүхэд төрөлхийн гажигтай төржээ. Харин 2014 оноос 2015 оны эхний зургаан сар буюу 1.5 жилийн хугацаанд 1280 хүүхэд гажигтай төрсөн гэсэн судалгаа гарсан байна. Өөрөөр хэлбэл, шинээр төрж байгаа хүүхдийн 0.8 хувь нь гажиг, согогтой байжээ.

УДМЫН САНГИЙН
ХОЛБОО 10 ДАХЬ ҮЕЭС
ХАМААРЛГҮЙ БОЛДОГ

Хүний аав, ээжээс нь дээш ес дэх үед удмын сангийн холбоо 0.19 хувь болж, 10 дахь үеэс огт хамааралгүй болдог ажээ. “Есөн үеийн дотор ураг холбохыг цээрлэнэ” гэдэг

монгол ёс заншлын утга үүний илэрхийлэл. Иймээс есөн үеэ бүрэн мэддэг болоход, цус ойртолтоос сэргийлэхэд угийн бичиг зайлшгүй хэрэгтэй гэдгийг эрдэмтэд хэлж байна.

Угийн бичиг хэрхэн хөтлөх талаар Монгол ураг удам, уламжлалын холбооны тэргүүн Ж.Түдэвдоржоос тодрууллаа.

-Угийн бичиг гэж юу вэ?

-Угийн бичиг гэж нэг удамтай ах дүү, төрөл төрөгсдийг хүн бүрээр тэмдэглэж, үе улируулан хөтлөхийг хэлнэ. Нэг ёсондоо удам угсааны тайлбар толь гэсэн үг юм даа.

-Угийн бичгийг хэрхэн хөтлөх вэ?

-Юуны өмнө удам угсааныхаа тухай мэдээллийг цуглуулах хэрэгтэй. Эхлээд ойр дотнын хүмүүсээсээ асууж сурагла. Бүр цаашлаад Үндэсний архивын газарт хандаж болно. Учир нь тайж, ноёдын угсаа гаралтай холбоотой бичиг баримт, хүн амын тооллогын баримтууд тэнд хадгалагдаж байдаг юм. Энэ хоёр төрлийн аргаар та өөрийн удмын хүмүүсийнхээ мэдээллийг цуглуулснаар угийн бичиг, удмын түүхээ бичих нэгэн аргыг олж авна. Харин харц гаралтай

жирийн хүний угийн бичгийн тэмдэглэл байдаггүй. Тиймээс тухайн хүнтэй холбогдолтой, түүний гэр бүлийн гишүүдийн нэр зэрэг мэдээллийг хүн амын тооллогын баримтуудаас авч болдог. Дараа нь угийн бичгээ бүртгэх хэрэгтэй. Мөн дээшээ есөн үе, доошоо есөн үеийн удмынхаа нэршлийг мэддэг байхад угийн бичиг хөтлөхөд дөхөм байдаг. Одоо техник технологи хөгжсөн болохоор угийн бичиг хөтлөхөд амар болсон.

-Угийн бичиг хөтлөхийн ашиг тус нь юу вэ?

-Хүн өөрийн овог удам, ястан үндэстний гарал үүсэл, ард түмнийхээ ёс заншлыг мэдэж, эх орноо хайрлан, түүх соёлоо дээдлэх, монгол хэлнийхээ үг хэллэг, түүний хөгжлийг мэдэн хөгжүүлэхэд зайлшгүй хэрэгтэй. Хамгийн чухал нь садан төрөл хүмүүс хоорондоо гэр бүл болсноос цус ойртон, үр удмын маань ухаан санаа булингартан, бие цогцос хэврэгшин, галбир үзэмж доройтох зэрэг удамшлын өвчнөөс сэргийлдэг. Энэ мэтчилэн тун чухал зүйл болохыг залуучууд төдийгүй монголчууд маань үл оогоорох нь үндэстний хэмжээнд мөхөх аюул нүүрлээд буйг илтгэж байгаа юм. [ЗГМ]

ҮЙЛЧИЛГЭЭ
Уран бичлэгээр
амилсан
эртний соёлЗ.Гэрэл
ЗГМ

Шангрила Молл-д Монголын археологийн болон эртний соёлыг уран бичлэгээр амилуулсан нэгэн үйлчилгээ нээгдээд удаагүй байна.

Эртний хадны сүг зураг, Хүннүгийн соёл болон домогт гардаг хөх чоно, гуа марал зэрэг Монголын уугуул соёлыг илтгэх олон дурсгал урлагийн хэлээр хүмүүст хүрч эхэллээ.

График дизайнер, уран бичээч Э.Ариунболд Хүннү болон Их Монгол Улс, цаашлаад Монголын Эзэнт гүрний үед хамаарах түүх дурсгалыг босоо монгол бичгээр урлагийн хэлбэрээр бүтээж буй нь энэ. Ингэхдээ тухайн цаг үеийн уйгаржин бичгийн тиг, зурлагыг хадгалсан гэдгийг зориуд онцлоё. Тухайлбал, Цогт тайжийн Дуутын хадны бичээсийг эх хувийг нь дуурайлган, алтан үсгээр амилуулжээ. Тэрбээр эл бүтээлийг хоёр сар гаруйн хугацаанд бүтээсэн байна.



Мөн Хүннүгийн үеийн цагаан толгойн үсэгнүүдээр бугын дүрсийг тойруулан чимэглэсэн нь үндэсний өв соёлоороо бахархаж, омогших сэтгэл төрүүлнэ. Уран бичээч Э.Ариунболд эл бүтээлийнхээ талаар “Кирилл болон бурууны цагаан толгойн бүх элементийн эх үндэс Хүннүгийн цагаан толгойд байсан. Залуу үе маань энэ сайхан өв соёлоороо дэлхийд бахархах, омогших үзлийг нь би урлагийн хэлээр дамжуулан хүргэхийг зорьдог” гэв.

Эг ийм хэлбэрээр Их засаг хууль, “Монголын нууц товчоо”, их найрагч Д.Нацагдоржийн “Би монгол хүн” шүлэг, “Үлэмжийн чанар”, “Түвшин сайхан аялгуу” зэрэг дууны найргийг “сийлжээ”.

Уг бүтээлээр Япон, АНУ-д үзэсгэлэн гаргах урилга хүлээж аваад буй тэрбээр захлалын дагуу хүмүүсийн нэр, онч мэргэн болон сургааль үгсийг урнаар бичиж буй аж. [ЗГМ]

UBshop.mn
ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ПЛАТФОРМ

Юу авмаар байна? Юу зармаар байна?

АВТОМАШИН

- 1 Ачааны зориулалттай автомашин маш хямд зарна
Утас: 96481125, 99087992
- 2 Автомашинны хагарч цуурсан шил наагч зарна.
Хүргэлттэй. Үнэ: 35000 төгрөг
Утас: 99679962
- 3 Шинэ дугуйнууд зарна.
Үнэ: 100.000 төгрөг
Утас: 88006734
- 4 Agiom шинэ дугуйнууд зарна
Утас: 99101688 /Үнэ тохирно/
- 5 2009 оны "FX35" хямд зарна.
Үнэ: 25 сая төгрөг
Утас: 99111468
- 6 "G500" зарна 2004-2012. Дотор гаднагүй он залуу болгосон машин оролцуулна.
Утас: 99993434
- 7 2003 оны 2012 орж ирсэн сувдан цагаан өнгөтэй, beams-2.0 мотортой, ухрах камертай "Grand mark 2" яаралтай зарна. Үнэ 5 сая төгрөг. Утас: 96651794
- 8 2009 оны "HUMMER H2" зарна. Утас: 91777877
- 9 2008 оны "LX570" зарна. Үнэ: 60 сая төгрөг
Утас: 99111468
- 10 "Full option A8" зарна.
Утас: 99995108

КОМПЬЮТЕР БА
ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ

- 1 Гэр болон оффиссын сүлжээ хүрдэггүй газарт сүлжээ дахин дамжуулагч суурилуулна.
Угсралт тохиргоо үнэгүй.
Утас: 75752020
- 2 Black iPad mini Wi Fi 64GB багтаамжтай. Үнэ: 400.000 төгрөг
Утас: 88998138
- 3 Ipad-1 wifi 16gb зарна.
Утас: 99002508
- 4 Төмөр гадаргуутай 2TB багтаамжтай зөөврийн hard диск зарна.
Утас: 98886655
- 5 "Sony Vaio core i5" notebook хямд зарна.
Үнэ: 500.000 төгрөг
Утас: 88102740
- 6 Sony 15.6 Core I7 560-d зарна. model VPCF133FX Intel(R) Core(TM)i7 Q740 1.70 ghz Ram 4g hhd 500gb Display 15.6 inch numlock
Утас: 88771767
- 7 "Kory notebook shop" бүх төрлийн used нөтбүүк, таблет худалдааж байна. Үнийн хувьд хамгийн хямд, өргөн сонголттой. Өдөр бүр 11.00-20.00 цагийн хооронд ажиллана. Утас: 89997986

ҮЛ ХӨДЛӨХ

- 1 Ар хустайн зусланд цэвэр агаарт хаус зарна. 2011 онд ашиглалтанд орсон төмөр бетон суурь, төмөр бөс бетон, 38-ийн дан тоосго, гадна талд хөөсөөр дулаалсан 200м2, 2давхар, машины гражтай, 380в цахилгаантай, цахилгаанаар бүрэн халдаг, 96м гүнээс худагийн ус гарсан цэвэр устай, халуун устай, цэвэр бохироо бүрэн шийдсэн өвөл зуны дулаахан чанартай сайн барьсан. - Нийт 6 өрөө, гал тогоо, зочны өрөө, 2 ариун цэврийн өрөөтэй, гал тогоо 00-д халуун устай, вакум цонх, паркетин шалтай дотор интерьер засал сайн.
Утас: 99289768
- 2 10-р хороололд Сувилахуйн сургуулийн хойно 47м.кв хоёр өрөө байр зарна. Утас: 88192130
- 3 Төмөр замд СОТ-н таван давхарт угсармал байрны хоёр өрөө байр зарна. Утас: 99466494
- 4 Хүүхдийн Паркийн замын урд зам дагуу төвийн шугамд холбогдох боломжтой 300м2. -22-н товчоо тойргийн хажууд зам дагуу Iга 380 тогтой блокон хашаатай газар.
-Хонхорт зам дагуу 9200м2 төвийн шугамд холбогдох боломжтой, худалдааны төв, шатхуун түгээгүүр, аж ахуй, агуулах, хөнгөн үйлдвэр зориулалтаар ашиглах боломжтой газар.
-Эмээлтэд 5га газар.
Утас: 99289768
- 5 Сансарын тунелд 1 давхарын гал тогоо тусдаа 3 өрөө байр зарна. Утас: 99760217, 99101271

НОМ, ХЭВЛЭЛ

- 1 Бүх төрлийн ном хэвлэл худалдааж байна.
Утас: 99144154
- 2 Хуучин номнууд зарна.
Утас: 94640105
- 3 Бизнес удирдлагын магистерийн ангид хэрэглэгдэх 2003-2008 оны Pearson's international edition номнуудыг тус бүр 30.000 төгрөгөөр зарна.
Утас: 99153637
- 4 Ээж ба хүүхэд ном зарна.
Утас: 99089401
- 5 Сэргэн мандалтын үеийн нэрт зураачдын бүтээлийг өнгөтөөр хэвлэж, орос хэлээр нийтэлсэн Монголд цөөн байдаг уран зургийн ном зарна.
Утас: 99625921
- 6 Official guide of TOEFL TEST 4th edition. Албан ёсны TOEFL тест гаргадаг газраас уг шалгалтад бэлтгэгчдэд зориулан гаргасан GUIDE book-ийн хамгийн сүүлийн хэвлэл. Хэрэглэж байсан мөн дисктэйгээ. Утас: 99674312
- 7 Монголын залуучуудад хүн төрөлхтний хөгжлийн их алхаатай хөл нийлүүлэхийн зэрэгцээ өөрийн үндэсний зан заншил, ухамсар, ёс суртахууныхаа үнэт зүйлийг гээгүй зөв хослуулан авч явахыг зөв ухамсарлан ойлгуулах энгийн хялбарар илэрхийлж чадсан “Монгол хүний хөгжил төлөвшлийн ДЭЭД УХААН” ном уншигчдын гэр дээр очиж байна.
Утас: 98111029
- 8 Өсвөр насныхны дээдэлж мөрдөх 7 зурилал ном зарна.
Үнэ: 30.500

ЦАХИЛГААН БАРАА

- 1 Электрон жин худалдана. Алт, мөнгөн эдлэл болон эмийн тунг жигнэх зориулалтай. Авсаархан хөнгөхөн. LCD дэлгэцтэй. 200 гр хүртэл Хэмжээ: 115X65X15 мм, Жин: 95 гр 1 минутанд автоматаар унтарна. Тэжээл: 2 ААА батарей (дагалдахгүй) Ажиллах температур: 10-30 хэм (С)
Утас: 88512938, 96012938
- 2 Модерн загварын ханын цаг (45-55cm) худалдана.
Утас: 96012938, 88512938
- 3 USB гагнуурын алх. Эгшин зуур хална, хөрнө. 480 С градус хүртэл хална.



Утас: 96012938

ХУДАЛДАНА

ПЯНЗ ХУДАЛДАНА. МОНГОЛ, ОРОС, БУСАД.

УТАС: 95777773

UBSHOP.MN

ubshop.mn сайтад та зараа байрлуулбал манай сонины зарын энэ хэсэгт шууд орох юм. Зөвхөн кирил үсгээр бичсэн, холбоо барих утас, зарах үнэ нь тодорхой зарууд энэ хэсэгт орохыг анхаарна уу.



Амьд ертөнц

Мартагдсан алаг даахай

Алаг даага тарваганы адил огт ус уудаггүй

Б.Баярмаа
@bayarmaaZGM

Долоон нарыг харвах амлалт-даа хүрээгүй Эрхий мэргэн харваач хурдан хүлгийнхээ урд хоёр хөлийг тайрч алаг даага болгосон гэх домгоор бид энэ амьтныг мэддэг. Харин дэлхий нийт “Дисней”-н хүүхэддэйн киноны гол баатар Мики маусыг алаг дааганаас санаа авсан гэдгээр танина. Ховордсон амьтдын тоонд бичигдсэн алаг даага буюу алаг даахай Монгол, Хятад, Какахастан, Кыргызстан зэрэг Азийн цөөн оронд бий. Мөн Африк тивийн хойд хэсэгт тэдний төрөл төрөгсөд цөөнгүй.

Дэлхий дээр алаг дааганы 33 зүйл байдаг бөгөөд үүнээс 20 гаруй нь Монгол оронд амьдардаг. Гаднын судлаачид алаг дааганы эрэлд гарахдаа Монголын говийг зүглэдэг нь тохиолдлын биш. Элсний тажигдаахай, говийн алаг даахай, соодон алагдаахай, монголжин даахай, зүүнгар даахай зэрэг зүйл нь зөвхөн Монгол болон Өвөр Монголын нутагт тааралддаг байна. Хамгийн анх 1970-1980 оны хооронд ОХУ-ын эрдэмтэн Г.Шенброт Монголын говь нутаг дахь алаг даага, түүний төрөл зүйлүүдийг судалжээ. Мөн 2007 онд Лондоны амьтан судлалын хүрээлэнгээс говийн алаг дааганы дүрсийг буулгасан байна. Үүнээс хойш тоймтой судалгаа хийгээгүй бололтой. Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнгийн эр-



ВВМ©

дэм шинжилгээний ажилтан Л.Амгалан “Одоогоор Монголд алаг даагыг судалсан хүн байхгүй. 30 гаруй жилийн өмнө ОХУ-ын эрдэмтэн Г.Шенброт ном хэвлүүлсэн байдаг. Судалгаа муу учраас тоо толгойн талаарх ямар ч мэдээлэл байдаггүй” гэв. Хэдийгээр алаг даахайн тоо толгойн талаарх мэдээлэл маруухан ч түүний амьдралын сонирхолтой хэв маягийн талаарх уншиж болно. Алаг даага бол халуун цөлд амьдрах чадвартай цөөхөн хөхтөн амьтны нэг. Туулай шиг том чих, хулгана шиг жижиг бие, имж шиг урт хойд хөл, элс шиг шаргал зүс нь говийн хатуу ширүүн уур амьсгалд тун сайн зохицсон.

Алаг даага хуурай цөлийн бүгчим өдрийг үүрэндээ өнгөрөөх бөгөөд халуун нар уулын цаагуур орсны дараа хоол олохоор үүрнээсээ цухуйдаг. Жижиг биетэй тэднийг үнэг, зэрлэг муур, могой, шар шувуу зоогоо болгохоор отож байдаг. Эдгээр араатнаас зугтахад нь түүний соргог чих, үнэрч хамар хамгийн сайн туслагч болно. Түүний дэлдэн чих зөвхөн сонсоход зориулагдаагүй, халуун нарнаас их биеийг хамгаалах үүрэгтэй. Гэхдээ алаг дааганы төрөл зүйлүүд хоорондоо чихээрээ ялгаатай. Цөөн хэдэн зүйл нь туулай шиг урт чихтэй байдаг бол бусдын нь харх эсвэл хулганы шиг

хэмжээтэй байдаг аж. Африкт амьдардаг жижиг чихтэй зарим зүйлийн алаг дааганаас улбаалан европчууд “цөлийн харх” гэж нэрлэх нь бий.

Алганд багтахар жижиг хэрнэ гурван метр хүртэл зайд харайдаг

Харин хөлийн урт, богино нь зүйл бүрт ижил. Тэднийг оройн зоогоо болгохоор гэтэж буй

хурц хараат үнэгнээс зугтахын тулд имж шиг урт сүүлээрээ тэнцвэрээ олон хойд хоёр хөлөөрөө харайна. Араатнаас зугтах үедээ цагт 24 км/цагийн хурдтай гүйдэг гэж тэмдэглэжээ. Алганд багтахар жижиг биетэй хэрнэ гурван метр хүртэл зайд харайдаг гэхээр гайхмаар.

Алаг даага тарваганы адил ус огт уудаггүй. Өвсний шимээр ундаалж, зарим зүйлийн шавжаар хооллодог. Ихэнхдээ говь, цөл нутагт тааралддаг ч заримдаа хээр, тал хээрийн бүсэд ч тэднийг олж харна. Тэд нэг гарцтай нүх ухааж, тэндээ амьдардаг. Зун цагт 3-6 зулзага төрүүлдэг бөгөөд монголчууд төлийг нь чойрон эсвэл ялман

гэж нэрлэдэг. Зарим ялман айлын хот руу орж, унтаж буй ямааны дэлэнг “суллагчид”. Гэхдээ алаг даага тийм ч гэр бүлсэг амьтан биш. Зун төрсөн ялмангууд хавар болоход үүрээ орхидог. Алаг даага хэдий жижигхэн ч хөлийн хурд, соргог мэдрэхүүдээ найдан ганцаараа хорвоог туулна. Энэ амьтан төрөл зүйлээсээ хамаарч 2-6 жил амьдардаг байна.

Тэднийг монголчууд байгалийн “цаг уурч” гэж нэрлэх нь бий. Учир нь говьд элсэн шуурга болох эсвэл бороо орох гэж буйг алаг даахайн аж байдлаас мэдэж болно. Борооны улирал дөхмөгц энэ бяцхан мэрэгч амьтад элснээс холдож уулархаг газар нүхээс ухдаг.

Сонирхуулахад, Монголд амьдардаг алаг даага бусдаасаа онцлог. Манай орон жилийн дөрвөн улиралтай учраас тэд ч бас үүнд дасан зохицох хэрэгтэй болдог аж. Тиймээс зуны улиралд идэш, тэжээлээ нөөцлөөд өвлийн хүйтэнд ичдэг байна.

Манай оронд байдаг элсний тажигдаахай, говийн алаг даахай, соодон алаг даахай, монголжин даахай, зүүнгар даахай зэрэг зүйл нь ховордсон, эсвэл ховордох эрсдэлтэйд багтдаг. Гэтэл хамгаалах бодлого байтугай тоо толгойн талаарх мэдээлэл ч үгүй мартагджээ. Тэдний тоо толгой цөөрсөөр байгаа нь малын бэлчээр хүрээгээ тэлсэнтэй холбоотой гэж тайлбарлах нь бий.

Хүн төрөлхтөн бяцхан алаг даахайг сонирхон өхөөрдөхөөс цаашгүй байна. Алганд багтахар, гэм хоргүй энэ амьтныг гаршуулахад тун хэцүү. Маш хурдан хөдөлгөөнтэй учир гарт баригдахгүй. Шөнийн амьдралтай учраас хүнтэй зохицон амьдрах нь юу л бол. [ЗГМ]

СОНИРХУУЛАХАД

Хамгийн дорой нь хулсны баавгай

Дэлхийн хамгийн ухаантай амьтан гэвэл сармагчин, далайн гахай, нохой, заан гээд амархан тоочиж чадна. Харин амьтдын ертөнцөд сэтгэн бодох чадвараараа хамгийн сүүлд ямар амьтад жагсадаг вэ гэдэг сонин.

Энэ жагсаалтыг өхөөрдөм хулсны баавгай тэргүүлдэг. Учир нь хулсны баавгай төрөлхийн маш залуу. Үр төлөө ч асарч халамжилдаггүй зан нь тэдний тоо толгой цөөрөхөд

багагүй нөлөөлжээ. Тэдний тархины хөгжил муу байдаг нь хулсанд хангалттай илчлэг байдаггүйтэй холбоотой гэж тайлбарладаг. Хулсны баавгай хэдийгээр өвсөн идэштэн ч өлсөөд ирэхийн цагт мах, түүхий өндөг гээд тааралдсан болгоноо иддэг. Хээлтэй болсон эм баавгай төрөх хүртлээ үүнийгээ мэддэггүй гэж судлаачид тэмдэглэжээ. Тийм ч учраас дөнгөж төрсөн

зулзагаа хараад айх, цохиж алах тохиолдол гардаг байна. Эсвэл унтаж байхдаа зулзагаа дарж алах нь ч бий.

Харин “мэдрэмжгүй” хулсны баавгайн “садан” уутгаг баавгайг яг нялх хүүхэд шиг гэдэг. Тэдний тархины хэмжээ биенийхээ хоёр хувьтай тэнцэхүйц жижиг. Гаднаа тайван амгалан харагддаг ч балчир хүүхэд шиг идэж буй модны навч, сууж буй мөчрөө булаалдан зодолддог аж. [ЗГМ]

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

СЭТГҮҮЛЧ:

Ажлын байрны үндсэн зорилго: Мэдээний шууд болон шууд бус хөтөлбөрүүдэд мэдээ сурвалжилга бэлтгэж нийлүүлэх, хөтөлбөрт мэдээ танилцуулах, мэдээний болон техникийн ажилтнуудтай багаар хамтран ажиллах.

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

- Эдийн засаг, бизнесийн тодорхой салбарыг хариуцан ажиллаж, мэдээ сурвалжилга бэлтгэх
- Салбарын бизнес, зах зээлийн судалгаа хийх, биржид бүртгэлтэй компаниудын тайлан, гол үзүүлэлтүүдэд анализ хийх, төлөв таамаг бэлтгэж танилцуулах
- Шууд болон шууд бус хөтөлбөрт мэдээ, сурвалжилга танилцуулах, зочидтой ярилцах, яриа авах

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Сэтгүүл зүй, хэл шинжлэлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн
- Олон улсын харилцаа, бизнес, санхүү, эдийн засгийн чиглэлээр дээд боловсрол эзэмшиж, зах зээлтэй холбоотой аль нэг салбарт ажиллаж байсан, эсвэл зохих ойлголт, мэдлэгтэй бол давуу тал болно
- Монгол хэлний яриа, бичгийн дүрмийн мэдлэг, найруулан бичих чадвар шаардсан ажил хийх туршлагатай
- Мэргэжлийн ёс зүйтэй
- Мэдээллийг цуглуулах, судалгаа шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай.

ОРЧУУЛАГЧ:

Ажлын байрны үндсэн зорилго: Мэдээний шууд болон шууд бус хөтөлбөрүүдэд гадаад мэдээ сурвалжилгыг орчуулан бэлтгэж нийлүүлэх, шууд хөтөлбөрт гадаад мэдээний синхрон орчуулга хийх, гадаад нэвтрүүлгийн орчуулга хийх, бүтээлийн багуудтай хамтран ажиллах.

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

- Олон улсын харилцаа, эдийн засаг, улс төр, бизнесийн салбарын мэдээлэл орчуулах
- Дээрх сэдвээр шууд болон шууд бус хөтөлбөрт орчуулга хийх,
- Олон улсын сүлжээ, агентлагуудаас хүлээн авсан мэдээ сурвалжилга, ярилцлагыг орчуулах, дуу оруулах

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Англи хэлний орчуулагчийн бакалавраас доошгүй зэрэгтэй (орос хэлтэй бол давуу тал болно)
- Эдийн засаг, бизнесийн салбар, танин мэдэхүйн нэвтрүүлгийн орчуулга хийх бүрэн чадвар, туршлагатай (аман болон бичгийн орчуулга хийж байсан туршлагатай бол давуу тал болно)
- Англи, монгол хэлний яриа, бичгийн дүрмийн мэдлэг, найруулан бичих чадвар шаардсан ажилд туршлагатай
- Эдийн засгийн аль нэг салбар, зах зээлтэй холбоотой ажил хийж байсан, эсвэл зохих ойлголт, мэдлэгтэй бол давуу тал болно.

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай
- Телевизийн салбарт удаан хугацаанд тогтвортой ажиллах хүсэл эрмэлзэлтэй
- Бусадтай харилцах, өөрийгөө зөв илэрхийлэх ур чадвартай
- Интернэтийн орчинд ажиллах, компьютер ашиглах мэдлэгтэй, программ дээр ажиллах чадвартай
- Багаар болон бие даан ажиллах, манлайлах, ажлын ачаалал даах чадвартай байх.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл, анкет
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээ, их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхийн хуулбарыг нотариатаар батлуулсан байх
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын дотор авахуулсан)
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Анкетыг “BLOOMBERG TV MONGOLIA” телевизийн байранд ирж бөглөх бөгөөд бүрдүүлэх материалыг хүлээлгэн өгнө үү.

Хаяг: Блю Скай таур, 4 давхар, № 403, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14240, Монгол Улс, Хөлбөө барих утас: 70102020

Шилдэг САНАА

Bloomberg TV Mongolia

Пүрэв гараг /2017.02.23/

20:30

11:30 Баасан гараг /давталт/

Амралтын өдрүүдэд

Лавлах

ШАЛГАРУУЛАЛТ

Төслийн уралдаан зарлалаа

Б.Бямба
ЗГМ

Монгол Улсын БСШУСЯ, БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн яам хооронд байгуулсан хөтөлбөрийн хүрээнд 2017 оноос хэрэгжүүлэх хамтарсан төслийн уралдаан зарлалаа. Энэхүү судалгааны төсөл нь хоёр талын сонирхолд нийцсэн, Монгол-Хятадын эрдэмтдийн хамтран гүйцэтгэх ажлууд байх юм. Нийт 10 хүртэл хамтарсан төсөл сонгон шалгаруулах бөгөөд 2-3 жилийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Монголын талын төслийг ирэх сарын 17-ныг хүртэл БСШУСЯ-нд, Хятадын талын төслийг ирэх сарын 5-ныг хүртэл БНХАУ-ын ШУТЯ-нд хүлээн авна. Монгол, Хятадын эрдэмтэд төслийн агуулгыг урьдчилан тохиролцож, талуудын оролцоог тодорхой болгосон байх шаардлагатай аж. [ЗГМ]

ДҮҮРЭГ

Багахангайд 3.4 тэрбум төгрөг зарцуулна

Нийслэлийн Багахангай дүүрэгт энэ онд нийт 3.4 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт хийхээр төлөвлөжээ. Энэхүү мөнгөний 1.7 тэрбум төгрөгийг Аврах гал унтраах 80 дугаар ангийн депогийн барилга, цэвэр, бохир усны шугам сүлжээ, усан сан, насосны станц, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл шинэчлэлд зарцуулах юм байна.

Харин 1.5 тэрбумыг Эрүүл мэндийн төвийн 40 ортой эмнэлгийн барилга, дулааны шугам сүлжээ солих болон орон сууцны хороолол дундах автозамуудыг шинэчлэхэд зориулахаар төлөвлөсөн гэдгийг Засаг дарга С.Эрдэнэ-баяр хэллээ. Түүнчлэн гудамж талбайн гэрэлтүүлэг, гэр хорооллын агаарын шугам солих зэрэг ажилд зарцуулах 151 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сан, дүүргээс гаргах юм байна. [ЗГМ]

ХӨТӨЧ

Томоохон захууд амрахгүй



Сар шинийн баяр дөхөж байгаагаар холбогдуулан томоохон зах, худалдааны төвүүд энэ долоо хоногт амрахгүй ажиллана. “Нарантуул” олон улсын худалдааны төв битүүний өдөр буюу хоёрдугаар сарын 26-нд 10.00-18.00 цагийн хооронд ажиллана. Харин шинийн 1-нээс гуравдугаар сарын 8-н хүртэл амрах юм байна.

“Дунжингарав” худалдааны төв битүүний өдөр хагас ажиллах бөгөөд 10.00-12.00 цагт үүдээ нээх юм байна. Харин “Хархорин”, “Бөмбөгөр” захууд битүүний өдөр 10.00-18.00 цаг хүртэл ажиллаж, хоёрдугаар сарын 27-ноос гуравдугаар сарын 1-нийг дуустал амрах хуваарь гаргажээ. Гуравдугаар сарын 2-ноос ихэнх худалдааны төв, захууд ердийн цагийн хуваарийн дагуу ажиллах юм байна. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	08.10 "Энэ бол дуурь" баримтат кино /Бүгд л тэгдэг/	07.30 "Сайн уу дэлхий" нэвтрүүлэг	09.00 "Cook Club" хоолны шоу нэвтрүүлэг	09.30 Тог тог тог /season-3/ 82 дугаар хэсэг
12.00	11.20 "Цаг үе, үзэл бодол"	11.00 "Made In Mongolia. Улаанбаатар гурил ХХК" нэвтрүүлэг	11.15 "Агуу тэсрэлтийн онол" ОАК. 8-9 дүгээр анги	11.40 "Гурван баавгай" хүүхэддэйн кино 53 дугаар анги
14.00	15.20 "Сэргэлэн Николая" уран сайхны кино	14.00 "Эзэнт гүрнийг босгосон нь" нэвтрүүлэг	14.10 "Зөв үнийг таа" шоу нэвтрүүлэг	14.00 "Нүүрс" баримтат кино 8 дугаар анги
18.00	18.20 "Хоймор өнжих нар" ОАК 18 дугаар анги	17.00 "Bloomberg Surveillance"	17.50 "Дэлхийн атлас" танин мэдэхүйн нэвтрүүлэг	17.30 Тог тог тог /season-3/ 83 дугаар хэсэг
20.00	21.10 "Нүүдэл" цуврал нэвтрүүлэг	20.00 "Блумбергийн ярилцах цаг" нэвтрүүлэг	21.00 "80 саяын уналт" асуулт, хариултын шоу нэвтрүүлэг	21.00 "Эмч нар" СОАК 9 дүгээр анги
22.00	22.10 "Чулуун дух" уран сайхны кино	22.00 "Байршил" нэвтрүүлэг	22.05 "Шадар гурван цэрэг" ОАК 6 дугаар анги	22.30 "Скандал" ОАК /season-5/ 4 дүгээр анги

ОНЦЛОХ ҮЗВЭР

"Мөсний баяр-2017"



"Хөх сувд-2017" олон улсын мөсний баяр гуравдугаар сарын 3-нд болно. Мөсний баярын үеэр морин чарга, тэшүүрчид, нохой чарганы парад болно. Мөн 271 км үргэлжлэх унадаг дугуйн аялал, мөсөн дээрх сүмо барилдаан, сурьин харваа, шагайн тэмцээн, үндэсний хувцасны өвлийн загварын үзүүлбэрүүд болон монгол үндэсний сайхан хувцастай иргэнийг шалгаруулах юм байна. Гадна, дотнын жуулчдад зориулсан хөгжөөнт тэмцээн зохиохоос гадна бөөгийн зан үйлтэй танилцуулахаар зэхсэн нь хамгийн сонирхолтой байж мэдэх юм. Түүнчлэн мөсний баярт оролцогчдыг мөсөн урлан бүтээх уралдаан, мөсөн гэрт зочлох зэрэг олон адал явдалтай арга хэмжээ хүлээж байна. [ЗГМ]

ҮЗВЭР

УЛСЫН ФИЛАРМОНИ
"Бүсгүй минь инээмсэглэж яваарай" олон улсын эмгэгтэйчүүдийн баярт зориулсан тоглолтыг ирэх сарын 8-нд 19.00 цагт тоглоно.

УДБЭТ

"Морин хуур 2016" шилдэг дуу шалгаруулах наадам энэ сарын 23-нд 19.00 цагт болно.

"Хүндлэн золгоё" концерт энэ сарын 25-нд 17.00 цагт болох гэж байна. "Үүлэн заяа" монгол дуурийг ирэх сарын 4-нд 17.00 цагт толилуулана.

"Цэнхэр нүдэн бүсгүй" романтик бүжгэн жүжгийг ирэх сарын 5-нд 17.00 цагт тоглоно.

"ИМАХ" КИНО ТЕАТР

Манголд Жамесийн бүтээл "Logan" кино ирэх сарын 3-нд нээлтээ хийх гэж байна.

МҮЭСТӨ

"Цагаан сар" үзэсгэлэн худалдаа энэ сарын 26-ныг хүртэл үргэлжилнэ. Үзэсгэлэнд тавгийн боов, цагаан идээ, гарын бэлэг, дээл, гоёл чимэглэл гээд олон төрлийн бүтээгдэхүүн худалдаж байна.

SHANGRI-LA MALL

XVII жарны Гал тахиа жилийн сар шинийн баярыг угтан үндэсний шилдэг үйлдвэрлэгчид, гар урчууд, бизнес эрхлэгчид оролцох үзэсгэлэн худалдаа энэ сарын 26-ныг дуустал үргэлжилнэ.

THE CORPORATE HOTEL AND CONVENTION CENTRE

"Төгөлдөр хуурчийн домог" (The Legend of 1900) киноны "Playing Love" хэмээх хайрын сүлд дуугаар нэрлэсэн энэхүү тоглолт гуравдугаар сарын 7, 8-нд 19.00 цагт болно.

ЗУРХАЙ



Билгийн тооллын 26

Өвлийн адаг цагагчин үхэр сарын гурван хөх мэнгэтэй цагаан луу өдөр. **Үс засуулбал:** Жаргал үргэлжид ирнэ. **Наран ургах, шингэх:** 07.42-18.26 **Барилдлага:** Рашаан **Шүтэн барилдлага:** Тийн мэдэхүй **Суудал:** Гал

Аргын тооллын хоёрдугаар сарын 22. Буд гараг. Билгийн тооллын 26, Суулга одтой, цагаан луу өдөр.

Өдрийн наран 07.42 цагт мандан, 18.26 цагт жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, лус тахих, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.


ГАЛТ ТЭЭРЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

Москва-УБ	21.35	07.30
УБ-Эрхүү	21.10	02.40
Эрхүү-УБ	15.35	06.20
УБ-Замын-Үүд	20.00	07.50
Замын-Үүд-УБ	21.35	09.55
УБ-Эрдэнэт	20.30	07.45
Эрдэнэт-УБ	19.10	05.48
УБ-Сүхбаатар	10.55	19.52
Сүхбаатар-УБ	06.30	15.35
Сайншанд-УБ	20.25	07.01
УБ-Сайншанд	09.15	19.15
Зүүнхараа-УБ	04.25	08.40

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бээжин	08.15	11.50
Бээжин-УБ	11.30	14.00
Сөүл-УБ	13.00	15.50
УБ-Сөүл	17.10	21.15
Москва-УБ	00.00	07.10
УБ-Москва	08.20	10.10
УБ-Хөх хот	08.00	10.20
Хөх хот-УБ	11.20	14.10
Бэрлин-УБ	13.15	06.15
Токио-УБ	15.30	20.25
УБ-Манжуур	16.50	19.25
Манжуур-УБ	16.50	19.25

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:

- Дэлхийн байгал хамгаалах сангийн бэлгэ тэмдэг (лого)-нд заларсан амьтан
- Анх удаа ороо, нийлүүлэгэнд орж буй мал, зарим амьтны нас
-хүйтэн
- Африкийн зэрлэг адуу
- Байгал нуурт цутгадаг Оросын гол мөрөн
- Адууны уналгын хэрэгсэл
- Мал амьтны өвчин
- Мал адгуусны хивдэг шүд
- "Долоон голтой" аюултай мэрэгч
- Дэлхий ертөнцийг нарны хорт ягаан туяанаас хамгаалдаг
- Элсэн далайн "хөлөг"
- Богд Хан уулын баруун талд орших даваа
- Эрэгчин зэрлэг гахай
- Нэгэн төрлийн матар
- Дэлхийн устаж, үгүй болсон амьтдыг бүртгэдэг ном
- Томоохон

давхарга
13. Уналгын морьд

ХӨНДЛӨНГӨӨР:

- Гурван толгойтой бүргэд сүлдэндээ залсан улс
- Элсэн далайн "хөлөг"
- Богд Хан уулын баруун талд орших даваа
- Эрэгчин зэрлэг гахай
- Нэгэн төрлийн матар
- Дэлхийн устаж, үгүй болсон амьтдыг бүртгэдэг ном
- Томоохон


- хэвлээр явагч
13. Монгол орны гол мөрөнд байх засаг
15. Дэлхийн шинжлэх ухаанд Прежвальскийн адуу гэж нэрлэгдсэн зэрлэг адуу
14. Явах дургүй, хойрго морь

Өмнөх дугаарын хариу /02.21




ЦАГ АГААР

УЛААНБААТАР	II.22	II.23	II.24	II.25	II.26
	-8° /7 м/с -20° /6 м/с	-6° /7 м/с -19° /5 м/с	-4° /8 м/с -18° /4 м/с	-2° /6 м/с -16° /4 м/с	-1° /5 м/с -14° /4 м/с
	Багавтар үүлтэй	Багавтар үүлтэй	Багавтар үүлтэй	Үүл багасна	Үүлшинэ



ЗГМ: КОМИКС



[ЗГМ]

"ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ" Сонины онлайм захиалга үргэлжилж байна.

"ZGM-FINANCIAL TIMES-NYT" ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД 5000 ТӨГРӨГ

99903581, 70103131

УНШИГЧ ТА МАНАЙ Сонины НИЙТЛЭЛ, МЭДЭЭ, СУРВАЛЖЛАГАТАЙ ХОЛБООТой САНАЛ ХҮСЭЛТЭЭ

OPED@ZASAG.CO

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Оросын хэвлэл Дональд Трампыг "хайрлахаа" болилоо

Макс Седдон

ОХУ-ын телевизийн ням гарагийн мэдээллийн шоу сүүлийн хэдэн сарын турш АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампыг Владимир Путинээс илүү харуулж байлаа. Гэвч ноён Трамп үндэсний аюулгүй байдлын зөвлөх Майкл Флиннийг ОХУ-тай холбогдсон хэргээр халж, Кремлийн дургүйг хүргэсэн хэд хэдэн мэдэгдэл хиймэгц түүнийг дэлгэцнээ гаргахыг үндсэндээ зогсоолоо.

Ноён Трампыг сайшаахаа багасгаж, урьдны магтаал "ташаа" байсан тухай тайлбарлахыг ОХУ-ын хүн амын 80 хувийнх нь мэдээллийн гол эх булаг болдог телевизийн компаниудад Москвагаас үүрэг болгосон талаар Кремлийн хэвлэлийн төлөөлөгч Дмитрий Песков тайлбарлав.

Мэдээллийн чиг хандлага огцом өөрчлөгдсөн нь ноён Трамп АНУ-ОХУ-ын харилцааг хүсэж байсанчлан шуурхай шинэчлэхгүй нь гэдгийг Москва ойлгосны илрэл юм. "Интерфакс" агентлагийн судалгааг үзвэл нэгдүгээр сард ОХУ-ын мэдээллийн хэрэгслүүд АНУ-ын удирдагчийг ОХУ-ын Ерөнхийлөгчөөс илүү анхаарсан нь хуучин цагтсан бол санаанд багтамгүй хэрэг байв.

Харин ням гарагт ОХУ-ын төрийн мэдээллийн хэрэгслийн хөтөлгөч Дмитрий Киселёв долоо



ВВМ©

хоног тутмын "Вести недели" нэвтрүүлгийг хөтлөхдөө ноён Трампыг дурдаад өнгөрлөө. Ноён Киселёв урьд нь АНУ-ын шинэ Ерөнхийлөгчийн талаар амьсгаа даран үзмээр онц сонирхолтой нэвтрүүлэг бэлтгэдэг байсан юм. Ноён Путиний нэр хүндийг унагаж мэдэхүйц, "Трампыг өргөмжилсөн" нэвтрүүлэг явуулдаг хэмээн ОХУ-ын

парламент дахь хэт барууны үзэлт гишүүдийн бүлэг Киселёвыг шүүмжилсэн удаатай.

Харин өнгөрсөн долоо хоногт ноён Киселёв Цагаан ордны шинэ эзний талаар цөөн товч тайлбар хийх зуураа, АНУ-ын мэдээллийн хэрэгсэлтэй хийж буй хэрүүл нь ноён Трампд гай болж байгаа талаар өгүүлэв. "ОХУ-тай харилцаагаа хэвийн

болгох ямарваа оролдлогыг Америкийн хэвлэлүүд автоматаар Москвагийн явуулга гэж хөрвүүлдэг. Мэдээллийнхний энэхүү байр сууринаас болоод Трампын нэр Америкийн ард түмний дайсан гэсэн утгатай боллоо" хэмээн тэрбээр тайлбарлав.

Владимир Соловьев хөтөлдөг, ОХУ-ын төрийн телевизийн ням гарагийн улс төрийн ток

шоунд оролцсон улстөрчид ноён Трампын нэрийг дурдахаас зайлсхийж, Москвагийн дуртай сэдэв болох НАТО-гоос тус улсад учруулж буй аюул заналын талаар ярилцсан юм. ОХУ "Пуужингаас хамгаалах АНУ-ын системийг өнөөдөр, маргааш, нөгөөдөр ч зад цохиж чадах" шинэ баллистик пуужин бүтээж байгаа талаар тус улсын Ерөнхий

сайдын цэрэг, аж үйлдвэрийн хэрэг эрхэлсэн орлогч Дмитрий Рогозин саяхан мэдэгдэв.

Өнгөрсөн долоо хоногт ноён Трампын хийсэн тайлбар нь Москва Крымыг Украинд эргүүлэн өгнө хэмээн Цагаан ордон тооцоолж буйг харуулж, АНУ-ын Ерөнхийлөгч олонхын таамаглаж байсан шиг ОХУ-ын тал баримтлагч биш юм байна гэсэн бодол төрүүллээ. Юутай ч Кремль АНУ-ын Ерөнхийлөгчийн тухайд "Хэрээс хэтэрсэн найдлага өвөрлөсөн удаагүй тул гутрах шалтгаан байхгүй"-г ноён Песков тайлбарлав.

Мэдээллийн хэрэгслүүдэд Дональд Трампыг талархан дэмжсэн тайлбарыг хамгийн ихээр өгч байсан эрхмийн нэг, парламентын үндсэрхэг үзэлт гишүүн Владимир Жириновский хүртэл АНУ-ын сонгуулийн дараахан Төрийн Думад хундага өргөсөн "алдаа"-гаа цайрууллаа. "Трампыг бидний анд болох болтугай хэмээн намайг хундага өргөсөн гэж америкчууд бодоо юу? Тэгвэл америкчууд андуурч" хэмээн тэрбээр "Комсомольская правда"-д тайлбарлав. "Америк хэзээ ч бидний анд байгаагүй. Бид бол өрсөлдөгчид, өөр өөрийнхөөрөө л байх болно" хэмээн ноён Жириновский өгүүлсэн юм.



Япончууд гадаадынхныг түлхүү хөлсөлнө

Японд ирж буй жуулчдын тоо өссөнтэй уялдан үйлчилгээний салбарт ажиллах гадаадын ажилчдад тавьдаг оршин суух эрхийн шаардлагаа Токио султгаж байна.

Тус улс 2016 онд түүхэндээ байгаагүй буюу 24 сая гаднын жуулчин хүлээн авчээ. Жуулчид ихэссэнээс шалтгаалан ресторан, зочид буудал зэрэг үйлчилгээний газруудад гадаад хэлтэй ажилчин дутагдах боллоо. Токио 2020 он гэхэд Японд ирэх жуулчны тоог 40 саяд хүргэх төлөвлөгөөтэй тул байдал цаашид бүр хүндрэх төлөвтэй.

Одоохондоо Японд суралцдаг гадаадын оюутнууд энэхүү цоорхойг бөглөж өгдөг. Өнгөрсөн оны аравдугаар сарын байдлаар, тус улсад суралцдаг гадаадын 209 мянган оюутан түр ажил эрхэлж байсан нь таван жилийн өмнөхөөс 2.3 дахин өссөн үзүүлэлт хэмээн Японы хөдөлмөрийн яам тайлбарлав. Зочид буудал, хүнсний үйлдвэрлэлд түр ажилладаг оюутнууд тус улсын гадаад ажилчдын 56 хувийг бүрдүүлж байна.

Засгийн газар бизнесийн зөвлөх, судлаач зэрэг өндөр ур чадвар шаарддаг мэргэжилд гадаадынхныг хөлслөхийг чухалчилдаг. Энэ оны эцсээс өмнө хүчин төгөлдөр үйлчилж эхлэх шинэ хуулиар, уг ангилалд багтдаг гадаадын иргэд тус улсад байнга оршин суух эрхтэй болно. Гэхдээ ур чадвартай гадаадын иргэдийг хөлслөх Японы хөтөлбөр нь орлого, боловсролын түвшин, ажилласан хугацаа зэрэгт олон хатуу шаардлага тавьдаг. Уг тогтолцоо нь нарийн мэргэжлийн ур чадвартай гадаадын олон иргэн тус улсад ажиллах боломжийг хааж байна хэмээн зарим нь шүүмжилдэг.

Эдүгээ Японы Засгийн газар өндөр ур чадвартай мэргэжилтнүүдээс тусад нь ангилал үүсгэхээр төлөвлөж байна. Энэ ангилалд багтах гадаадын ажилчид стратегийн тусгай бүсэд ажиллах тохиолдолд оршин суух эрх авахад тавьдаг шаардлага зөөлөн байх юм. Уг хөтөлбөр нь Японд суралцах



ВВМ©

зуураа ажилладаг гадаадын оюутнуудад түшиглэдэг үйлчилгээний салбарын ажиллах хүчний дутагдлыг нөхөж өгнө.

Орчуулагч, тогооч, соммелье буюу рестораны дарсны үйлчлэгч, хувцас загварын дизайнер зэрэг ажил мэргэжил энэхүү шинэ ангилалд багтжээ. Гадаадын иргэн уг ангиллаар байнга оршин суух эрх авах бол 10 жилээс багагүй ажлын туршлага хуримтлуулсан юм уу, дор хаяж коллежийн боловсролтой байх шаардлагатай.

Ихэнх нь Токио, Осака зэрэг том хотод оршдог, стратегийн ач холбогдолтой 17 тусгай бүс дэх гадаадын ажиллах хүчний асуудлыг багтаасан бизнес төлөвлөгөөг Японы Засгийн газрын кабинет удахгүй шалгана. Тусгай бүсүүд нь хөтөлбөрийн дагуу зөвшөөрөл олгосон ажил мэргэжлээр гадаадын иргэдийг ажиллуулах юм. Эх орондоо болон Японд мэргэжлийн зэрэг эзэмшиж, олон улсын уралдаан тэмцээнд байр эзлэж байсан бол харгалзан үзэж, туршлага хуримтлуулсан хугацаа зэрэг хатуу шаардлагыг зөөлрүүлэхээр зааж өгчээ.

Мөн эх орондоо япон хэлний мэргэжлийн шалгалтад тэнцсэн хүмүүст Японы зочид буудалд ажиллах зөвшөөрөл олгож болзошгүй байгаа юм. Осака хотын захиргаа Японы аюулгүйн алба, аялал, жуулчлалын салбарт

ажиллах гадаадын иргэдэд тавьдаг шаардлагыг султгахыг тус улсын Засгийн газарт уриалж байна.

Японы Засгийн газрын Хөдөлмөрийн шинэчлэлийн зөвлөл гадаадын ажилчдыг тус улсад нэвтрүүлэх асуудлаар энэ лхагва гарагт цогц хэлэлцүүлэг өрнүүлнэ. Хэлэлцүүлгээр Японы үйлдвэрлэл, үйлчилгээний салбар тус бүрт шаардлагатай гадаадын ажилчдын тоог тодорхойлох асуудлыг хэлэлцэх юм.

Японд ажиллах хүсэлтэй гадаадын иргэдэд тавьдаг шаардлагыг хөнгөвчлөх нь тус улсын ажиллах хүчний хомсдлыг шийдвэрлэхэд тус болоод зогсохгүй хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих ач холбогдолтой. Хувцас загварын дизайнер зэрэг ажил мэргэжлээр гадаадын иргэдийг хөлслөх нь Японы соёлыг хилийн чанадад түгээн дэлгэрүүлэхэд ч тус дөхөм болно. Харин консерватив үзэл бодолтнууд тус улсад гадаадын ажилчдын тоо нэмэгдэхэд түлхэц өгөх энэхүү арга хэмжээг шүүмжилж байгаа.

"Гадаадынхныг ажиллуулдаг тусгай бүсүүд япончуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж чадвал цаашид нийт улс даяар ийм тогтолцоо үүсгэж ч болох юм" хэмээн уг төлөвлөгөөнд ойр эх сурвалж тайлбарлав.



10th ANNIVERSARY
KEMPINSKI HOTEL
KHAN PALACE

Кемпински Хаан Палас Зочид буудлын
10 жилийн ой тохиожж буй
"Алтан унжлагат" гал тахиа жимс
Айл гэрт тань инээд хөөр цалгижж,
Ажил үйлс тань амжилт бүтээлээр
дүүрэн байхыг хүсэн ерөөе.

Эрхэм үйлчлүүлэгч та бүхэн
Сар шинэдээ сайхан шинэлээрэй!

Кемпински Хаан Палас Зочид буудал
У +976 11 463 463
и reservations.ulaanbaatar@kempinski.com
kempinski.com/ulaanbaatar

